

# “МӨНГӨН НУРУУ” ХХК -ИЙН СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН

# 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**/ MV- 022165, РД 6470556/**

2025 он

## ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ....................................3

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл ....................................3

1.2 Төслийн байршил....................................3

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ....................................7

2.1 Байгаль орчны төлөв байдал....................................7

***Судалгааны үр дүн*** ....................................10

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ....................................17

3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл.........19

3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл ....................................19

3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл ....................................20

3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл....................................22

3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл ....................................22

3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл ....................................22

3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл....................................23

3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл....................................23

3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл....................................23

3.11 Хуримтлагдах нөлөөлөл....................................24

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ....................................26

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.......27

ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....................................30

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....................................34

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....................................35

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ....................................36

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР....................................41

АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ....................................55

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....56

## ТАЙЛАНД ОРСОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл* ....3
*Хүснэгт 2. Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол* ....4
*Хүснэгт 3. Хөрсний дээж авсан цэгийн байршил* ....10
*Хүснэгт 4. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл* ....11
*Хүснэгт 5. Ургамлын ангилалзүй* ....13
*Хүснэгт 6. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа* ....17
*Хүснэгт 7. Гол нөлөөллийн дүн шинжилгээ* ....17
*Хүснэгт 8. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ* ....21
*Хүснэгт 9. Автомашины утааны бүрдэл найрлага* ....21
*Хүснэгт 10. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл* ....24
*Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн нотолгоо* ....27

## ТАЙЛАНД ОРСОН ЗУРГАН МЭДЭЭЛЭЛИЙН ЖАГСААЛТ

*Зураг 1.Төслийн талбайн байрзүйн зураг* ....4
*Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг* ....5
*Зураг 3. Засаг захиргааны зураг* ....6
Зураг 4. Талбайн физик газарзүйн мужлалын зураг....7
*Зураг 5. Төслийн талбайн районы ландшафтын зураглал* ....8
*Зураг 6. Монгол орны Хөрс-газарзүйн мужлалын зураг* ....10
*Зураг 7. Төслийн талбайд хээрийн ажил хийх үеийн зураг* ....10
*Зураг 8. Төслийн талбайн хөрсний хэв шинж* ....11
*Зураг 9.Монгол орны ургамал – газарзүйн мужлал* ....13
*Зураг 10. Төслийн талбай ба сав газрын хил* ....15
*Зураг 11.Төслийн талбайн хил Туул голоос 200 метр зайд* ....16

# НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## *1.1 Төслийн ерөнхий мэдээлэл*

*Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл*

| | |
|---|---|
| *Төслийн нэр:* | • “Дэнж алтны шороон ордыг ашиглах” төсөл |
| *Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:* | • “Мөнгөн нуруу” ХХК<br>Регистрийн дугаар: 6470556 |
| *Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас* | • Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 03 дугаар хороо, Агро центр, 904 тоот,<br>Утас: 88015024, 99109815 |
| *Төслийн товч тодорхойлолт* | • Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газрын 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн шийдвэрээр Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Дэнж” нэртэй 290.05 га талбайд ашигт малтмал ашиглах MV-022165 дугаартай тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгосон.<br>• Ил уурхайгаас 104.9 мян. м3 элс олборлож, 32.69 кг алт олборлохоор тооцоолсон ба ил уурхайн техникийн хүчин чадалд үндэслэн ашиглалтын хугацаа 3 жил байх бөгөөд химийн цэврээр 32.90 кг алт гаргах бөгөөд уурхайгаас Сэлэнгэ аймаг дахь Монгол банкны алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн төвд тушаахаар тооцсон байна. Уурхайд нийт 47 хүн ажиллах бөгөөд дундаж цалин 1389.0 сая төгрөг байна. |

## *1.2 Төслийн байршил*

“Мөнгөн нуруу” ХХК-ийн эзэмшдэг MV-022165 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Дэнж” нэртэй талбай нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн M-48-106 тоот хавтгайд 290.05 га талбайг хамран оршино.

- Талбайн хэмжээ: 290.05 га




*Зураг 1.Төслийн талбайн байрзүйн зураг*

*Хүснэгт 2. Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбилцол*

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 104 | 37 | 27.81 | 48 | 42 | 50 |
| 2 | 104 | 37 | 27.81 | 48 | 41 | 12.75 |
| 3 | 104 | 37 | 0.19 | 48 | 41 | 12.75 |
| 4 | 104 | 37 | 0.19 | 48 | 41 | 31.54 |
| 5 | 104 | 36 | 35.59 | 48 | 41 | 31.54 |
| 6 | 104 | 36 | 35.59 | 48 | 42 | 49.13 |
| 7 | 104 | 36 | 35.63 | 48 | 42 | 49.18 |
| 8 | 104 | 37 | 0.26 | 48 | 42 | 49.18 |
| 9 | 104 | 37 | 0.26 | 48 | 42 | 50 |




*Зураг 2. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг*




*Зураг 3. Засаг захиргааны зураг*

# ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН

# ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## *2.1 Байгаль орчны төлөв байдал*

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум нь хойд өргөргийн 49° 40' 54" - 49° 42' 00", зүүн уртрагийн 107° 12' 30" - 107° 19' 10"-ийн хооронд оршино. Тус сум нь Тарвагатай, Баянцагаан гэсэн 2 багийн нийт 283.6 мянган га нутаг дэвсгэртэй. Түүний 105 мянган га талбай нь ХАА-н эдэлбэр бөгөөд нийт нутгийн 61.8 хувийг ой мод эзэлдэг.Сумын төвийн нэр нь Булагтай.2023 оны байдлаар нийт 2299 хүн амтай. Төслийн талбай нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хангайн мужийн хэсэгт Орхон-Сэлэнгийн савын дундаж өндөр уулсын тойрогт байрлана.

Төслийн талбай нь физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж, Хангайн муж, Орхон, Сэлэнгийн савын дундаж өндөр уулсын тойрогт багтаж байна.




**Зураг 4. Талбайн физик газарзүйн мужлалын зураг**

Төслийн талбайн газрын гадаргын үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 815-1004 метрийн хооронд хэлбэлзэж, тэгш талыг хамарч тогтворжсон байна. Газрын гадаргын налуу буюу хэвгий 0°-11° (градус) байна




*Зураг 5. Төслийн талбайн районы ландшафтын зураглал*

**Цаг уурын нөхцөл:** Нутаг дэвсгэрийн уур амьсгал бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсийн дотроос газарзүйнбайрлал ба газрын гадарга, нарнаас ирж буй цацраг илч, агаарын орчил хөдөлгөөн зэрэг бие биетэйгээ нягт холбоотой хүчин зүйл голчлон нөлөөлнө.

Судалгааны талбайн уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүдийг Өвөрхангай аймгийн Нарийнтээлсумын цаг уурын харуулын 2015-2020 оны мэдээг ашиглан боловсруулла.

Судалгааны талбай орчмын газар нутаг нь ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай. Өвлийн улиралд гэнэтийн дулааралт бараг ажиглагддаггүй бол зуны улиралд гэнэтийн хүйтрэлт хааяа тохиолдоно. Агаарын температурын бас нэг онцлог бол хавар, намрын улирал богинохон, халуун хүйтний солилцоо эрс байдаг явдал юм.

Нарийнтээл сумын нутаг өндөр уул нуруу багатай газрын гадаргын хэв шинж бараг нэг төрлийн учраас байгалийн ба уур амьсгалын нөхцөл нь онцын ялгаагүй уур амьсгалын голлох үзүүлэлт хур тунадас температур ургамлын ургалтын хугацааны чийгийн хангамжийн үзүүлэлтийг уур амьсгалынмужлалын гол үзүүлэлт болгон авч болно.

Нарийнтээл сумын нутаг дэвсгэр нь уур амьсгалын хувьд чийглэгдүү сэрүүвтэр мужид хамрагдана.

Сүүлийн 6 жилийн мэдээллээр жилд дунджаар 86.8-243.8 мм тунадас, дулааны улиралд 163.5мм, хүйтний улиралд 12.8 мм тунадас тус тус орох ба чийгийн хүрлцээ ерөнхийдөө сайн байдаг. 1-рсарын агаарын дундаж температур -12.6°C – -20.5 °C орчим хүйтэн, 7-р сарын агаарын дундаж температур 17.8°C – 21.6°C орчим дулаан байдаг ба жилийн хамгийн их дулаан байдаг 30.7°C, хамгийн бага нь -31.5°C хүрч хүйтэрч байсан байна.

Энэ нутаг дэвсгэрт дундаж температур хавар 4-р сарын сүүлийн арав хоногоос 10 градусыг дайрч дулаардаг бөгөөд намар 9-р сарын эхний арав хоногт 10 градус болж цаашид буурдаг. Анхныхүйтрэл 9 дүгээр сарын 12-20-ны хооронд, эцсийн хүйтрэл 4-р сарын 19-24-ний хооронд тохиолдоно.

**Хөрсний шинж чанар:** Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Дэнж нэртэй газар орших “Мөнгөн нуруу” ХХК-ийн Алтны ил шороон орд газарт хийсэн хөрсний хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнг тусгав.

*Судалгааны талбайн хөрсөн бүрхэвчийн онцлог*

Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн хархүрэн, хүрэн хөрсний дэд бүсийн Орхон-Шаамарын 1-р тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2022).




*Зураг 6. Монгол орны Хөрс-газарзүйн мужлалын зураг*

***Судалгааны үр дүн***

Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн Төслийн районд нугын хээржсэн хөрс тархсан байна.

*Хүснэгт 3. Хөрсний дээж авсан цэгийн байршил*

| Цэгийн дугаар | Дээжний нэр | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|
| 1 | Зүсэлт-1, А-0-20 | 104° 36' 56.6" | 48° 42' 1.29" |
| 2 | Зүсэлт-2, АВ | 104° 36' 48.93" | 48° 41' 39.40" |



*Зураг 7. Төслийн талбайд хээрийн ажил хийх үеийн зураг*




*Зураг 8. Төслийн талбайн хөрсний хэв шинж*

*Хүснэгт 4. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл*

| Хөрсний морфологи бичиглэл | | |
|---|---|---|
| *Хөрсний зүсэлтийн дугаар* | | Зүсэлт-1 А-0-20 |
| *Байршил* | | Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум Хонгор Овоо 3-р баг |
| *Координат* | | 48° 42' 0.48" N |
| | | 104° 36' 57.72"E |
| *Өндөр* | | д.т.д 815-1004 метр |
| *Газрын гадарга* | | $0\text{-}11^{0}$ |
| *Ургамлын бүрхэвч* | | 72% |
| *Хөрсний нэр* | | Нугын хээржсэн хөрс |
| *Хөрсний фото* | *Гүн* | Морфологи шинж чанар |

| Хөрсний морфологи бичиглэл | | |
|---|---|---|
|  | **А.** 0 -20<br>20 см | Хүрэн өнгөтэй, нягт, хуурай, ургамлын үндэстэй, жижиг сайр чулуутай, бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй. |
| Хөрсний морфологи бичиглэл | | |
| *Хөрсний зүсэлтийн дугаар* | | Зүсэлт-2 АВ Талбайн урд хэсэгт |
| *Байршил* | | Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум Хонгор Овоо 3-р баг |
| *Координат* | | 48° 41' 39,40" N |
| | | 104° 36' 48.93"E |
| *Өндөр* | | д.т.д 815-1004 метр |
| *Газрын гадарга* | | $0\text{-}11^0$ |
| *Ургамлын бүрхэвч* | | 72% |
| *Хөрсний нэр* | | Нугын хээржсэн хөрс |
| *Хөрсний фото* | *Гүн* | Морфологи шинж чанар |
|  | **А.** 0 -20<br>40 см | Хүрэн өнгөтэй, нягт, хуурай, ургамлын үндэстэй, жижиг сайр чулуутай, бүдэг илэрсэн бөөмөрхөг бүтэцтэй. |

**Ургамал зүйн байдал:** Төслийн талбай нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).




*Зураг 9.Монгол орны ургамал – газарзүйн мужлал*

Төслийн талбайн орчимд 2024 оны 07 дугаар сард 16 овгийн 24 төрлийн 31 зүйл ургамал бүртгэв. Төрөл зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болно.

*Хүснэгт 5. Ургамлын ангилалзүй*

| № | Шинжлэх ухааны нэр | Монгол нэр | Амьдралын хэлбэр | Статус | аж, ахуйн бүлэг |
|---|---|---|---|---|---|
| **1.** | **Poaceae-Үетэний овог** | | | | |
| 1 | *Stipa krylovii* | Крыловын хялгана | Өвслөг | Бэлчээр | Үетэн |
| 2 | *Agropyron cristatum* | Саман ерхөг | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Үетэн |
| 3 | *Cliestogenes squarrosa* | Дэрвээн хазаар | Өвслөг | Бэлчээр | Үетэн |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | *Leymus chinensis* | Нангиад түнгэ | Өвслөг | Бэлчээр | Үетэн |
| 5 | *Achnatherum splendens* | Гялгар дэрс | Өвслөг | Бэлчээр | Үетэн |
| 6 | *Poa attenuatta* | Туужууны биелэг | Өвслөг | Бэлчээр,э / ашигт | Үетэн |
| **2. Cyperaceae - Уулалжийн овог** | | | | | |
| 7 | *Carex duriuscula* | Ширэг улалж | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Улалж |
| 8 | *Carex stenophylla* | Нарийн навчит улалж | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Улалж |
| **3. Rosaceae – Сарнайн овог** | | | | | |
| 9 | *Potentilla acaulis* | Навтуул гичгэнэ | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| 10 | *Potentilla verticillaris* | Тойруулгат гичгэнэ | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| 11 | *Potentilla tanacetifolia* | Маралзгана навчит гичгэнэ | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| 12 | *Potentilla bifurca* | Имт гичгэнэ | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| **4. Ranunculaceae – Холтсон цэцэгтэн** | | | | | |
| 13 | Pulsatilla turczaninovii | Турчинановын яргуй | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| **5. Chenopodiaceae- Луультан** | | | | | |
| 14 | *Salsola collina* | Толгодын бударгана | Өвслөг | Дүүргэгч, э/ ашигт | Лууль |
| 15 | *Chenopodium aristatum* | Дэргэвэр лууль | Нэг наст | Дүүргэгч | Лууль |
| 16 | *Chenopodium acuminatum* | Шоргор лууль | Өвслөг | Дүүргэгч | Лууль |
| **6. Asteraceae – Нийлмэл цэцэгтэн** | | | | | |
| 17 | *Saussurea salicifolia* | Бургас навчит банздоо | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| 18 | *Scorzonera austrica* | Австрийн хависгана | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| 19 | *Artemisia adamsii* | Адамсын шарилж | Нэг наст | Дүүргэгч, э/ ашигт | Шарил ж |
| 20 | *Artemisia frigida* | Өлчир шарилж | З/сөөгөнцө р | Бэлчээр, э/ ашигт | Шарил ж |
| 21 | *Taraxacum officinalis* | Эмийн багваахай | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| 22 | *Heteropappus hispidus* | Арзгар согсоолж | Өвслөг | Бэлчээр | Алаг өвс |
| **7. Plantaginaceae - Тавансалааны овог** | | | | | |
| 23 | *Plantago major* | Их таван салаа | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| **8. Papaveraceae – Намуугийн овог** | | | | | |
| 24 | *Papaver nudicaulis* | Нүцгэн намуу | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| **9. Geraniaceae - Шимтэглэйн овог** | | | | | |
| 25 | *Geranium sibiricum* | Сибирь шимтэглээ | Дүүргэгч | Бэлчээр | Алаг өвс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **10. Alliaceae – Сонгинотоны овог** | | | | | |
| 26 | *Allium tenuissimum* | Нарийн навчит сонгино | Өвслөг | Бэлчээр х/ ашигт | Алаг өвс |
| **11. Brassicaceae – Тоонолжин цэцэгтний овог** | | | | | |
| 27 | *Ptilotricum canescens* | Буурал янгиц | Өвслөг | Бэлчээр | Алаг өвс |
| **12.Cannabiaceae – Олсны овог** | | | | | |
| 28 | *Cannabis ruderalis* | хогийн олс | Дүүргэгч | Бэлчээр | Алаг өвс |
| **14. Boriganaceae- Ноцоргоны овог** | | | | | |
| 29 | *Lappula myosotis* | Дурсгалжирхуу зангуу | Дүүргэгч | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| **15. Onagraceae- Хөвөнтийн овог** | | | | | |
| 30 | *Chamaenerion angistifolium* | Нарийн навчит хөвөн оройт | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |
| **16. Urticaceae- Халгайн овог** | | | | | |
| 31 | *Urtica cannabiana* | Олслог халгай | Өвслөг | Бэлчээр, э/ ашигт | Алаг өвс |

**Ус зүй:** Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газарт тус тус багтана.




***Зураг 10.*** *Төслийн талбай ба сав газрын хил*




*Зураг 11.Төслийн талбайн хил Туул голоос 200 метр зайд*

## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ

## ТОДОРХОЙЛОЛТ

*Хүснэгт 6. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа*

| Төслийн гол нөлөөлөл | Нөлөөлөлд өртөгч | Хамрах хүрээ | Сөрөг Нөлөөллийн эрчим | Үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад | | | | |
| Шатах тослох материал, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх | Гүний ус, гадаргын ус, ургамал | Төслийн талбай | Бага | Төсөл хэрэгжих хугацаанд |
| Зам, жим харгуй ихсэх | Агаар, хөрс, амьтан, | Авто зам түүний ойр орчим | Дунд | Төсөл хэрэгжих хугацаанд |
| Олборлолтонд өртөх | Газрын хэвлий | Төслийн талбай | Дунд | Төсөл хэрэгжих хугацаанд |

*Хүснэгт 7. Гол нөлөөллийн дүн шинжилгээ*

| Нөлөөллийн ангилал | Гол нөлөөлөл | Нөлөөллийн цар хүрээ | Нөлөөллийн эрчим | Нөлөөллийн үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл<br>• Бохирдуулах<br>• Эвдэх | • Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бохирддог.<br>• Хөрс эвдэх нөлөөлөлд уурхайн хөрсийг дураараа сэндийчих, барилга өргөтгөн барих ажлууд хамаарагдаж байна. | Төслийн эдэлбэр газрын хэмжээ | Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.<br>Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| • Доройтуулах | • Доройтуулах нөлөөлөлд автомашины хүн тээврийн маршрут, хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаалаагүй зэрэг хамаарагдаж байна. | | Хөрс доройтуулах нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна. | |
| 2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл<br>• Бохирдуулах<br>• Нөөцийг бууруулах | Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгарах зэрэг орно.<br>Газрын гүний ус ашигладаг учраас нөөцөд бага зэрэг нөлөөлнө. | | Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |
| 3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл<br>• Амьдрах орчинг хуваах<br>• Амьдрах орчинг доройтуулах<br>• Амьдрах орчинг хомсдуулах<br>• Нөөцийг бууруулах | Хүнд даацын хөдөлгөөн нь тэдгээрийн амьдрах орчныг хуваах, доройтуулах, хомсдуулах нөлөөллийг үзүүлж байна. | Төслийн эдэлбэр газрын хэмжээ | Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |
| 4. Агаарт үзүүлэх нөлөөлөл<br>• Бохирдуулах<br>• Тоос | Галлагааны зуухаас угаар, автомашины шатаасан хийн угаар нь агаарыг бохирдуулж түүний чанарыг доройтуулдаг.<br>Замын барилгын ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг. | Төслийн эдэлбэр газрын хэмжээ | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна. | Төсөл хэрэгжих хугацаанд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс<br>• Хамгаалах<br>Нүүлгэн шилжүүлэх | - | - | - | - |

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь хүнд даацын автомашины хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

### 3.1 Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл

- Гадаад болон дотоод овоолгыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, кемпийг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Шатах тослох материал асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах
- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

### 3.2 Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Овоолго барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь

бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

### *3.3 Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл*

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол харьцангуй бага байна гэж үзэж байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй учир тухайн төсөл хэрэгжих талбайн агаар нь харьцангуй цэвэр ба төслийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид уурхайн тээврийн хэрэгслийн ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

- Ургамалын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах
- Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд төсөл хэрэгжих орчин нь уул уурхайн бүс гэдгийг харгалзан үзэж хүний үйл ажилагаанаас үүдэлтэй тоосны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох нь нэн чухал юм.

Тээвэрлэлтийн /уурхайн олборлолтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, автомашин зорчих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг боломцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

**Хийн хаягдлаас үүсэх гол сөрөг нөлөөлөл**

Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулна. 1кг шатахууны литрт шилжүүлэн (бензин q=0.725, дизель q=0.825) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашины утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт болгодог.

*Хүснэгт 8. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ*

| **Бохирдол** | **Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед** | **Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)** | **Машин тойргоор эргэх үед** | **Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош )** |
|---|---|---|---|---|
| **CO (%)** | 4 – 9 | < 1 – 8 | 1 – 7 | 2 – 9 |
| **HC, $C_6H_{14}$ (ppm)** | 500 – 1000 | 50 – 80 | 200 – 800 | 3000 – 12 000 |
| **$NO_x$ (ppm)** | 10 – 50 | 1000 - 4000 | 1000- 3000 | 5 – 50 |

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав. Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

*Хүснэгт 9. Автомашины утааны бүрдэл найрлага*

| **№** | **Бүрдэл** | **Хөдөлгүүрийн төрөл** | | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| | | Бензин | Дизель | |
| **1** | Азот (%) | 74-77 | 76-78 | **Хоргүй** |
| **2** | Хүчилтөрөгч %) | 0.3-8 | 2-18 | **Хоргүй** |
| **3** | Усны уур (%) | 3-5.5 | 0.5-4 | **Хоргүй** |
| **4** | Нүүрсхүчлийн хий (%) | 5-12 | 1-10 | **Хоргүй** |
| **5** | Нүүрстөрөгчийн исэл (%) | 1-10 | 0.01-0.5 | **Хортой** |
| **6** | Азотын исэл (%) | 0.1-0.5 | 0.001-0.4 | **Хортой** |
| **7** | Альдегид (%) | 0.0-0.2 | 0-0.009 | **Хортой** |
| **8** | Нүүрс-устөрөгчид (%) | 0.01-0.02 | 0.01-0.5 | **Хортой** |
| **9** | Хүхэрлэг хий (%) | 0-0.002 | 0-0.03 | **Хортой** |
| **10** | Хөө тортог (г/м$^3$) | 0-0.44 | 0.01-1.1 | **Хортой** |
| **11** | Бенз (а) пирен (г/м$^3$) | <0.00002 | <0.00001 | Хортой |

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

### 3.4 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн их хэмжээний эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, хэсэг газар ургамал хөрс талхлагдаж, ухмал нүх үүссэн, одоогийн байдлаар бага зэрэг хог хаягдалтай байна.

Тус төсөл хэрэгжихэд нийт талбайн 31% буюу 15.0 га талбайн гадаргуу өртөгдөж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

**Төслийн олборлолтын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Газрын хэвлий ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлий бохирдох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

### 3.5 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газар нь хөрс газарзүйн мужлалтаар хөрс-био уур амьсгалын Хангайн мужийн өндрийн бүсшил бүхий Хангай-Хэнтийн өмнөдийн хэв шинж бүхий 52 дугаар тойрогт хамрагдана. Энд уулын бэлээр нугын, уулын хойд хажуугаар уулын ширэгт-тайгын, уулын хар шороон, уулын ойн бараан, уулын хар шороон, уулын хар хүрэн хөрснүүд тус тус тархана.

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

**Төслийн кемпийн барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

**Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

### 3.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Уурхайн олборлолт болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр

талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

**Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

### *3.7 Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл*

Төслийн талбай орчмын нутаг нь монгол орны амьтны аймгийн газар зүйн мужлалаар Олон нуурынхөндий мужид багтана.

**Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устах, хордох
- Төслийн олборлолтын ажлын үеийн тэсрэлт болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

### *3.8 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл*

Гадаргын болон гүний усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд, бичил бохир цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усыг тоосжилт болон ногоон байгууламжийн усалгаа зэрэгт эргүүлэн ашиглах, үер болохоос сэргийлж далан байгуулах, голын ойр орчимд ахуйн болон үйлдвэрийн бохирдлоос сэргийлэх хамгаалалтын төлөвлөгөө, анхааруулга сэрэмжлүүлэг бүхий самбар, мөн гүний ус ашиглалтыг хянах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг багтана.

**Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын гол горхины ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдах

### *3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл*

Уул уурхайн үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт багагүй орлого оруулах, зуны улиралд ажлын цөөнгүй байр гардаг нь ажилгүйдлийг багасгах, хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж байна. Тухайн орон нутгийн

экологийн чадавхаас хэтэрсэн ажил үйлчилгээ эрхлэх хэт олон том жижиг уурхай байгуулж хүн амын төвлөрөл бий болгох хөл хөдөлгөөн ихэсгэхээс аль болохоор зайлсхийх, бүс нутгийн дүрэм журмын дагуу зохих хязгаарлалт хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд нэгэнт байгуулагдсан болон байгуулах гэж буй уурхай нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн бага хэмжээнд хүртэл нь бууруулах талаар туйлын хариуцлагатай хандаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Төслийн олборлолтын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо оршин суугч иргэдэд нөлөөлөл үзүүлэх болно. Оршин суугч иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

### *3.11 Хуримтлагдах нөлөөлөл*

“Мөнгөн нуруу” ХХК-ийн алтны шороон орд төсөл нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын тухайн бүс нутагт уул уурхайн орд газруудын үйл ажиллагаа явагддаг ба төслүүдийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад уурхайн олборлолт, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

*Хүснэгт 10. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл*

| № | Хуримтлагдах нөлөөлөл | Нөлөөллийн шалтгаан | Хамрах цар хүрээ | Үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх | Бусад төслүүдийн нөлөөлөл | Төслийн талбай, нөлөөллийн бүс | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 2 | Газрын доорх усны нөөц багасах | Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал | | Одоо, ирээдүй |
| 3 | Гадаргын ус бохирдох | Бусад төслүүдийн нөлөөлөл | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 4 | Ургамлан нөмрөгийн доройтол | Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 5 | Агаарын бохирдол нэмэгдэх | Хуурайшилт, бусад төслүүдийн бохирдол | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |
| 6 | Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх | Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **7** | Амьтан дайжих, тоо толгой цөөрөх | Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал | | Өнгөрсөн, одоо, ирээдүй |

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

**2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

| № | Зардлын утга | Нийт зардал, төгрөг |
|---|---|---|
| 1 | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал | 200,000 |
| 2 | Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал | 3,000,000 |
| 3 | Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад хийгдэх ажлын зардал | 1,000,000 |
| 4 | Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал | 1,000,000 |
| 5 | Нөхөн сэргээлтийн ажлын зардал /*тэрбум мод/* | 25,000,000 |
| 6 | 6.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 13,000,000 |
| 7 | 7.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, нийгмийн хариуцлагын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | --*-- |
| 8 | Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал | 20,000,000 |
| 9 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 6,500,000 |
| 10 | Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал | 12,000,000 |
| 11 | Төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах зардал | 1,000,000 |
| 12 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал | 6,000,000 |
| | Нийт дүн | **88,700,000** |

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

"Мөнгөн нуруу" ХХК нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|
| | 1 | 2 | |
| 1. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлт батлуулах | Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд тусгасан | 2025 БОМТ батлуулсан. Хавсралтаар батлуулсан нүүрийг хавсаргав. 2025 оны биелэлтийн тайланг 2025 оны 10дугаар сарын 31ны өдөр цаасаар болон цахимаар хүргүүлэв. |


БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА — Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"МӨНГӨН НУРУУ" ХХК ЗАХИРАЛ — Л.ГАНСҮХ

"МӨНГӨН НУРУУ" ХХК НИЙ СЭЛЭНГЭ АЙМАГ, ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИНЭ. "ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ" ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-022165
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6470556

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ — Б. ЦОГТБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
"МӨНГӨН НУРУУ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — Х.ЗУЛСАР

2025 ОН

## ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Мөнгөн нуруу” ХХК нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ.

*Хүснэгт 11. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн нотолгоо*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | БИЕЛЭЛТИЙН ҮР ДҮН |
|---|---|---|---|
| **АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ** | | | |
| Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох | Зам талбай, овоолго, тоос босох гадаргуут усалгаа хийж тоосжилтын эсрэг зам усалгаа хийх | Уурхайн талбайд | Салхи ихтэй үед цистерн машинаар усалгаа хийлгэдэг.  |
| **УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх | Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/ | Ухаш, засварын газар | Засварын хэсэгт асгаралтын иж бүрдэл байршуулсан.  |
| **ХӨРС, ГАЗРЫН ГАДАРГАД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ** | | | |
| Хөрс талхагдлаас сэргийлэх | Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх | |   |
| Техникийн нөхөн сэргээлтийг арга зүйн дагуу хийгээгүй тохиолдолд хөрсөн бүрхэвч | • Техникийн нөхөн сэргээлтийг хийх | | |

| | | | |
|---|---|---|---|
| доройтох, нөхөн сэргэх чадвараа алдах | | | Хөрсний овоолго 3050м2 Эзэлхүүн 11590м3 үүсгэсэн. 2.72 га бүхий талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.  |
| **УРГАМЛАН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ** | | | |
| Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох | Шимт хөрсний овоолгыг стандартын дагуу байгуулах, хамгаалах | Уурхайн талбайд |  |
| **БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Амьтан хамгаалах | Шувууны суулт 2 ширхэг /үүр/ суурилуулах | Уурхайн гадна бүсэд |   |

Манай компани нь амьтан хамгаалах ажлын хүрээнд төслийн талбай дотор 1ширхэг үүрийг Монголын зэрлэг амьтан судлах, хамгаалах төвөөс 2022онд гаргасан заавар эмхэтгэлийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**Хүснэгт 1. Шувууны үүр болон суулт байршуулсан газарзүйн байршлын координат**

| Цэгийн дугаар | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 104 | 37 | 38.4 | 48 | 42 | 85 |
| 2 | 104 | 37 | 12.8 | 48 | 41 | 44 |

**Зураг 12. Шувууны үүр болон суулт байршуулсан байршлын зураглал болон заавар**









**Хиймэл үүр хийж байрлуулахдаа анхаарах зүйлс**

Та өөрийн гараар шувуудад амьдрах таатай орчин бий болгохын тулд хиймэл үүр хийхдээ дараах зүйлсийг анхаараарай. Үүнд:

- Шувуудад ээлтэй материал сонгох ба энэ нь хүйтэн, дулаанаас тусгаарласан, бат бөх байх нь хамгийн чухал.
- Ямар хэмжээтэй шувуунд зориулж үүр хийж байгаагаа анхаарах хэрэгтэй.
- Шувууны үүр байршуулах тохиромжтой газрыг олоорой.
- Шувууны үүрийг 4-р сарын эхэн болон дунд үед хийж байрлуулбал тохиромжтой байдаг.
- Үүрийг борооны ус орохоосгүй битүүмжлэл сайтай хийх ёстой.
- Хийсэн үүрээ мод, шонгийн мод, зуслангийн байшин зэрэг газарт суурилуулахдаа газраас дээш дунджаар 2-3 метрт тогтоогоорой. Харин хот орчмын байгууламжийн дундах модонд 3-5 метр өндөрт байрлуулах нь тохиромжтой. Гэхдээ зарим тохиолдолд арай намхан, эсвэл илүү өндөрт байрлуулах шаардлага гарч болдогийг анхаарна уу.
- Шувууны үүрийг байрлуулахдаа салхины уруу, модны нөмөрт, нарны хурц тусгал шууд тусахгүй газар байрлуулах хэрэгтэй.
- Нүхний амсарын доор шувуу суух саваа хийж болохгүйг анхаарна уу. Учир нь үүнийг ашиглаад томоохон шувууд эсвэл махчин амьтад суух, улмаар өндөг, ангаахайг идэх нөхцөл бүрддэг.
- Шувууны үүрний байрлал нь тэгш босоо байх бөгөөд удаан эдэлгээтэй материалаар хийгдэх ёстой. Мөн үүрийг хийхдээ дээвэр юмуу хажуу талыг нээгддэг зориулалтаар хийвэл жил бүр шувууны үүрийг цэвэрлэн, шувуудын үржлийг дэмжихэд тус дэм болно.

## ЗУРГАА.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, сая төг | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1. | Техникийн нөхөн сэргээлт- гадаад овоолго - Өөрийн техниктэй | - | га | - | - | Гадаад овоолго байхгүй. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | Техникийн нөхөн сэргээлт- дотоод овоолго - Өөрийн техниктэй | 2810 м3 ээзлхүүн хамарна. Олборлолтын үед дотоод овоолго үүсгэж явна | га | 5 | 5.0 | Хөрсний овоолго 3050м2 Ээзлхүүн 11590м3 үүсгэсэн  |
| 3. | Тэрбум мод тарих | Төслийн талбайд салхин доод талдаа модоор хашлага хийх *(Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгацын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)* | ширхэг | 3000 | 9.0 | Сэлэнгэ аймгийн Байгаль орчны газартай гэрээ хийсэн хавсралтаар оруулав. 3000мод 2026 оны 5сард тариулахаар Орхонтуул сумаас тариулахаар болсон |
| 4. | Биологийн нөхөн сэргээлт-шимт хөрс | 1.2 га газарт шимт хөрсний овоолго үүсгэнэ | га | 1.2 | 6.0 | Төслийн талбайн олборлолтод өртсөн 1.2 га бүхий газарт **Эвдэрсэн газрыг ургамалжуулах**. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5918: 2023 стандартын дагуу 1.2 га дунджаар ерхөг, согоовор гэсэн “төрлийн үрнээс тус бүр 25кг-ыг буюу нийт 50 кг үр худалдаж авч газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн. |
| | НИЙТ | | | | 20.0 | |

Төслийн талбайн олборлолтод өртсөн 1.2 га бүхий газарт **Эвдэрсэн газрыг ургамалжуулах**. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5918: 2023 стандартын дагуу 1.2 га дунджаар ерхөг, согоовор гэсэн 2 төрлийн үрнээс тус бүр 25кг-ыг буюу нийт 50 кг үр худалдаж авч газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн.

**Зураг 13. Шимт хөрсийг зөөвөрлөж асгаж буй байдал болон шимт хөрсийг тарааж үр тарьсаны дараах**









## ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, сая төг | Биелэлтийн үр дүн | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **1.** | “Нөхөн сэргээлт -2024 аян” | Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд гар аргаар ашигт малтмал олборлогч иргэд нарын улмаас эвдэрсэн 3 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж хүлээлгэн өгөх | гар аргаар ашигт малтмал олборлогч иргэд нарын улмаас эвдэрсэн газар | 3.0га | 60.0 | Орон нутгийн өгсөн чиглэлийн дагуу 3 га бүхий техникийн нөхөн сэргээлт хийсэн.  | | |

Нэгж талбарын дугаар:
Газар эзэмшигчийн овог нэр: Мөнгөн нуруу ХХК
Регистерийн дугаар: 6470556
Хаяг: Сэлэнгэ аймаг Орхонтуул сум

Нэгж талбар

| № | N | E |
|---|---|---|
| 1 | 49'24'02.40 | 107'20'56.20 |
| 2 | 49'23'59.00 | 107'20'54.40 |
| 3 | 49'24'04.50 | 107'20'48.00 |
| 4 | 49'24'01.80 | 107'20'45.60 |

| № | N | E |
|---|---|---|
| 1 | 49°23'53.20 | 107°21'10.30 |
| 2 | 49°23'54.50 | 107°21'12.30 |
| 3 | 49°23'47.30 | 107°21'23.10 |
| 4 | 49°23'46.20 | 107°21'21.30 |

Эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбилцуулсан үндэслэлийн цэг.
Цэгийн солбилцол 1: X....................Y....................H....................
Цэгийн солбилцол2: X....................Y....................H....................
Цэгийн солбилцол3: X....................Y....................H....................

Талбайн хэмжээ: 3га

Хэмжилт үйлдсэн:
Огноо:

Т. Бо... [signature]

Дүйцүүлэн хамгаалах байршлын орон нутгаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бага өлөнт нэртэй газарт эвдрэлд өртөөд орхигдсон газар 3 га бүхий газар өөрийн техникийн тусламжтайгаар техникийн нөхөн сэргээлтийг хийсэн болно. Дүйцүүлэн хамгаалах ажлыг хийхэд нийт 13 сая төгрөг зарцуулсан байна.

**Зураг 14 Дүйцүүлэн хамгаалах ажил хийх байршилд техникийн нөхөн сэргээлт хийсний дараах байдал**



**НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн ашиглалтын нөлөөллийн бүсэд малчдын хаваржаа болон зуслан, намаржаа байхгүй.

**ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

**АРАВ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, сая. төг | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1. | Ажилчид болон үйлчлүүлэгчийн бие өвдөх, халдварт өвчин гарах, | Ажилчдын эрүүл мэндийн үзлэг | Нийт ажилчид | 30 | -- | Улсаас хийж буй эрт илрүүлэгт оруулсан. |
| 2. | Гал түймэр гарах | Гал унтраах хэрэгслээр уурхайн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах /, утааны мэдрэгч, гал гарсан тохиолдолд ашиглах зориулалттай галын автомат гидрант, аврах шат, хаалга, тэдгээрийн байршлын тойм зураглал, яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбоо зэргээр бүрэн тоноглох/ | Нийт ажилчид | 30 | 1.0 |  |
| | **Нийт** | | | | | **1.0** |



Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/134 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0014257

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "Мөнгөн нуруу" ХХК

Хаяг: Сэлэнгэ аймаг Орхонтуул сум.

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл: Уул уурхайн

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад зохих дүгнэлтийг олгоно
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон 2024 он 10 сар 16 өдөр

Хүчинтэй хугацаа 2025 он 10 сар 16 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон

Сэлэнгэ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ дарга Хурандаа цолтой Г.Галбадрах

Дүгнэлт гаргасан

Сэлэнгэ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/ Гал түймрийн улсын хяналтын байцаагч Хошууч цолтой Д.Баясгалан

/тэмдэг дарна/





**Галын сарай болон бусад дагалдах хэрэгсэлүүд**

- Галын сарааны иж бүрдлийг гадаа талбайд байрлуулдаг ба галын аюулгүйн ажиллагааны тоног төхөөрөмжүүдийг иж бүрнээр нь багтаасан. Үүнд:
- -Хүрз тогтоогчтой элсний хайрцаг 1ш
- -Галын хувин 2ш
- -Галын дэгээ 2ш
- -галын хөнжил 2ш
- -Галын жоотуутай сүх 2ш
- -Царил 2ш
- -Галын цохиур 2ш
- -Галд тэсвэртэй бээлий 2ш
- -Гал унтраагуур ABC 4кг 2ш
- -Гал унтраагуур ABC 35кг 1ш
- -Гал унтраагуур CO2 2кг 2ш
- -Галын хорны уут 4кг 4ш
- -Галын хорны уут 35кг 1ш
- -Галын хөрөө 1ш
- -Лоом 2ш
- Хэмжээ: 120x120x150см



Зураг-1.. Засварын талбайг хатуу хучилттай болгосон байдал




Зураг-2. Галын сарай, галын хор, галын булан  000




Зураг-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбар, тэмдэг тэмдэглэгээ

## АРВАН НЭГ.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Ахуйн | Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх | Хог хаягдлын түр цэг | - | 100.0 | 3 |  |
| 2. | Аюултай | Аюултай хог хаягдал аккумлятор, ашигласан тос маслыг цуглуулж устгуулах мэргэжлийн компанитай гэрээ байгуулж зайлуулах | Хог хаягдлын түр цэг | - | - | 2.7 | Элемент ХХК-тай гэрээ байгуулсан. Хавсралтаар оруулав. |
| | Нийт | | | | | 3.0 | |

Энгийн болон аюултай хог хаягдлыг холбогдох байгууллагуудаар зайлуулдаг. Хавсралтаар гэрээний хуулбаруудыг оруулав.

**БАТЛАВ:**
**"ЭЛЕМЕНТ" ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**
**/Б.ЭНХБАДРАЛ/**

**БАТЛАВ:**
**"МӨНГӨН НУРУУ" ХХК-ИЙН**
**ЗАХИРАЛ**
**/Л.ГАНСҮХ/**

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

№ ХБ-25/...179...

2025 оны 09-р сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1. Нэг талаас "**Элемент**" ХХК РД: /2100061/ /цаашид "**Гүйцэтгэгч**" гэх/ түүнийг төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа, нөгөө талаас /цаашид "**Захиалагч**" гэх/-ыг **"Мөнгөн нуруу"ХХК** РД:/6470556/ түүнийг төлөөлж захирал Л.Гансүх нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг зориулалтын газарлуу ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.2. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

1.2.1 Устгал хийх хог хаягдлын мэдээлэл, үнэ /Хавсралт №1/
1.2.2 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг
1.2.3 Захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
1.2.4 "Элемент" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

**ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ**

2.1. Захиалагч дараах эрхтэй:
2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

БАТЛАВ:

СЭЛЭНГЭ АЙМАГ ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА:
................/М.ЦОГБАЯР/

МӨНГӨН НУРУУ ХХК-НИЙ ЗАХИРАЛ:
................/Л.ГАНСҮХ/

**ХОГ ХАЯГДАЛЫН ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

Орхонтуул сум — 2024 оны 02 сарын 20 өдөр

*ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО*

Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад гарсан ахиун хог хаягдлыг цаг хугацаанд нь шуурхай тээвэрлэж, цэвэрхэн эрүүл орчин бүрдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

*ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ*

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсгийн "д" дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 заалтууд, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 192, Б/243 тушаалуудыг тус тус үндэслэн нэг талаас Орхонтуул сумын Засаг дарга М.Цогбаяр нөгөө талаас Мөнгөн нуруу ХХК-ний захирал Л.Гансүх нар харилцан тохиролцож 2024 оны 02 дугаар сарын 15-наас 2025 оны 02 сарын 15-ны өдрийн хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Мөнгөн нуруу ХХКомпани нь өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдалыг тогтоосон цаг хугацаанд тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага тавих эрхтэй.

1. Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 96 тоот тогтоолоор хог хаягдалын хураамжийн хэмжээг сарын 50.000 мянган төгрөг, жилийн 600.000 мянган төгрөгөөр тооцож хог хаягдлын төлбөрийг гэрээ байгуулсанаас эхлэн ажлын 5 хоногт багтаан 100131000947 Хог хаягдлын хураамж тоот дансанд хийх.
2. Монгол Улсын "Ариун цэврийн тухай" хуулийн 7.4, 17.1.4 дэх заалтыг үндэслэн гадаад орчноо бохирдуулахгүй хог хаягдлыг төвлөрсөн цэгээс өөр газар хаяхгүй байх үүрэгтэй. Компани нь Монгол Улсын Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, устгах үүрэгтэй.
3. Тусгай эмнэлэгийн байгууллагын хог, цацраг идэвхит болон химийн хортой бодис үйлдвэрлэл, туршилт, шинжилгээний ажил хийх үед компани нь сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

*ЭРХ, ҮҮРЭГ*

1. Монгол Улсын Хог хаягдын тухай хуулийн 12 дугаар заалтыг үндэслэн аж ахуй нэгж байгууллага иргэдээс хог хаягдал гаргасаны төлбөрийг нэхэмжлэн авах эрхтэй.
2. Тусгай хог хаягдлын Засгийн газрын 2006 оны 238 дугаар тогтоол, сумын ИТХ-ын баталсан журмын дагуу зөөж тээвэрлэж, зайлуулж байх үүрэгтэй.

**АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Тус уурхайн 2025 оны 07 сарын 08,22нд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж Ус, цаг уур, шинжилгээний төв-өөр гүйцэтгүүлж дээжлэлт, сорьцыг стандартын дагуу авч тайлангийн үр дүнг оруулсан болно.

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хяналтын цэгийн байршил | Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, мян.төг | Нийт зардал мян.төг | Баримтлах стандарт, арга аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| **Агаарын чанар** | | | | | | |
| $CO_2$ , $NO_2$ $SO_2$ (PM10 PM 2.5) | Төслийн талбай орчимд 1 цэг | Жилд 1 удаа | 2 цэгт 1 удаа | 195.0төг*2 удаа | 390.0 | -MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага<br>- MNS 5002:2000 |
| **Хөрс** | | | | | | |
| Хөрсний агрохимийн үзүүлэлт | Төслийн талбайн эрүүл газрын хөрснөөс 3-цэг | Жилд 1 удаа | 3 цэгт 1удаа | Нийт 3 цэгт | 120.0 | - (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, |
| Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо | Хог хаягдлын цэг-1 | Жилд 1 удаа дулааны улиралд | 1 цэгт 1 удаа | 25.0төг | 250.0 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт) | Төслийн талбайн ил гарсан хөрснөөс 2-цэг | Жилд 1 удаа | 2 цэгт 1 удаа | Нийт 2 цэгт /26.0/*5 жил | 250.0 | хэмжээ стандарт - MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. |
| **Усны чанар** | | | | | | |
| Ерөнхий химИ | Унд ахуйн ус 1 цэг<br>Хаягдлын сан 1цэг | Жилд 1 удаа | 2 цэгт 1 удаа | 75.0төг*1удаа | 275.0 | -MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ |
| **НИЙТ ЗАРДАЛ ТӨГ** | | | | | **1,285 000 төг** | |

# ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЕЛЭЛТ

***Агаарын чанарын ерөнхий төлөв байдал***

Хүний амьсгалах агаар чанарын хувьд эрүүл ахуйн болон биеийн үйл ажиллагааны шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж хүний амьдралын орчны чанарыг хангахын тулд аливаа улс орон хүн амынхаа амьдрах орчны агаарын чанарын стандарт хэмжээ шаардлагыг тогтоож түүнийг тогтмол мөрдөж байх ёстой. Дэлхийн нийтэд агаарын чанарын үзүүлэлт, түүний эрүүл мэнд, экологид үзүүлэх сөрөг нөлөөллийн талаархи нарийвчилсан судалгааны үндсэн дээр ДЭМБ-аас зөвлөмж гаргасан байдаг ба энэ зөвлөмж дээр үндэслэн манай улсад 2007 онд агаарын чанарын стандарт буюу техникийн ерөнхий шаардлага шинэчлэгдэн 2008 оноос мөрдөгдөж эхэлсэн байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагчдын агууламжийг агаарын чанарыг үнэлэх гол шалгуур болох агаарын чанарын стандарт /MNS 4585:2016/ дахь бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ, зөвшөөрөгдөх түвшинтэй харьцуулан мөрдөж байна /доорх хүснэгтэнд харуулав/.

*Хүснэгт 12. Агаар дахь түгээмэл бохирдуулагчдын хүлцэх агууламж*

| **Үзүүлэлтийн нэр** | **Хэмжих нэгж** | **Хүлцэх агууламж, зөвшөөрөгдөх түвшин /жилийн дундаж/** |
|---|---|---|
| Хүхэрлэг хий ($SO_2$) | мкг/м$^3$ | 10 |
| Азотын давхар исэл ($NO_2$) | мкг/м$^3$ | 30 |
| Нүүрсхүчлийн хий буюу угаарын хий (CO) | мкг/м$^3$ | 10000 |
| Тоос, тоосонцор, | мкг/м$^3$ | 100 |
| Том ширхэглэгт тоосонцор / $PM_{10}$/ | мкг/м$^3$ | 50 |
| Нарийн ширхэглэгт тоосонцор / $PM_{2.5}$/ | мкг/м$^3$ | 25 |

***Агаар орчны судалгааны байршил, хамрагдсан цэгүүд***

*Хүснэгт 13. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил*

| Хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил | | Координат | |
|---|---|---|---|
| | | Уртраг | Өргөрөг |
| 1 | Кемп | 104°37'46.13"E | 48° 44'25.82"N |
| 2 | Олборлолтын талбай орчим | 104°37'45.19"E | 48° 44'24.48"N |



*Зураг 15.Агаарын хяналт шинжилгээ хийж буй үеийн зураг*

***Агаарын хяналт шинжилгээний үр дүн***

Агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас кемп болон олборлолтын талбай хэвийн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 14.Хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Азотын давхар исэлийн хий | PM 10 тоосонцор | PM 2.5 тоосонцор | Дуу чимээ /ДБА/ | Агаарын чанарын индекс | Агаарын чийгшил | Температур $^0C$ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Кемп | VIII/07 | 16:17 | 0.025 | 7.86 | 0.046 | 40 | цэвэр | 49% | 28.5 |
| 2 | Олборлолтын талбай орчим | VIII/07 | 16.11 | 0.031 | 0.823 | | 64.7 | цэвэр | 46% | 29.3 |
| Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт) | | | | 1800 | 100 | 50 | 60 | - | 30-60 | - |

***Агаар орчны хяналт шинжилгээний дүгнэлт, зөвлөмж***

Төслийн эзэмшил талбайд агаарын чанарын хяналтын 2 цэгээс авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй үзүүлэлттэй байна.

Шуугиан гэж янз бүрийн давтамжтай өндөр, нам авианы замбараагүй хослолыг хэлнэ. ДЭМБ-аас гаргасан судалгаагаар шуугианы шалтгаантай сонсгол бууралт нь дэлхийд хамгийн түгээмэл тохиолддог, урьдчилан сэргийлэх боломжтой мэргэжлээс шалтгаалсан өвчний нэг гэж үздэг [12].

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд ногоон байгууламж хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай учир нь модлог ургамал дуу чимээний бохирдлыг бууруулаад зогсохгүй орчны агаарыг цэвэршүүлэх ач холбогдолтой. Зайлшгүй шаардлагатай биш бол машины дуут дохиог хэрэглэхгүй байхыг ажилчдад анхааруулах.

***Ургамал болон хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээний судалгааны үр дүн***

*Хүснэгт 15. Төслийн талбайн ургамалжлын бичиглэл хийсэн цэгийн координат*

| Дээжний дугаар | Координат | |
|---|---|---|
| | Уртраг | Өргөрөг |
| Ургамлын бичиглэл-1 | 104°37'46.13"E | 48° 44'25.82"N |
| Ургамлын бичиглэл-2 | 104°37'45.19"E | 48° 44'24.48"N |

Төслийн талбайд бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь дааган сүүл-үетэнт, жижиг дэгнүүлт үетэн-хялганат оролцсон талхлагдсан бэлчээрийн төрөл байна.

*Хүснэгт 16.Ургамлын бичиглэл*

| № | Бэлчээрийн төрөл | Бэлчээрийн ургамалжлын шалгуур үзүүлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зүйлийн тоо (100м2 талбайд) | Зүйлийн тоо (1м2 талбайд) | Ургамлын бүрхэц,% | Олшрогч ургамлын бүрхэц,% | Халцгай газар, % | Хад, хайрга, чулуу,% | Хагд, % | Ургац, ц/га |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дааган сүүл-үетэнт (X-II-2-4) | 3-5 | 1-2 | 50 | 20 | 20 | 0 | 10 | 1,0 |
| 2 | Жижиг дэгнүүлт үетэн-хялганат (X-II-2-3) | 2-4 | 1-3 | 60 | 20 | 15 | 0 | 5 | 1,0 |

Тус нэгж талбарын ургамлан нөмрөг дунд зэрэг доройтсон байна.

**1. Дааган сүүл-үетэнт (X-II-2-4)**



*Зураг 16.Ургамлын бичиглэл-1*

**2. Жижиг дэгнүүлт үетэн-хялганат (X-II-2-3)**



*Зураг 17.Ургамлын бичиглэл-2*

***Ургамлан нөмрөгийн ашиглалт, доройтлын өнөөгийн түвшин***

Төсөл хэрэгжих орчны нутаг дэвсгэр нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших ба ургамалан бүрхэвч нь байгалийн хүчин зүйлсээс илүүтэйгээр антропогены нөлөөгөөр ургамлын төрөл зүйл хомсдсон. Төсөл хэрэгжүүлэгч талаас ногоон байгууламж биологийн нөхөн сэргээлт хийж байна.

***Хөрсөн бүрхэвчийн хяналт шинжилгээний судалгааны үр дүн***

Тус нэгж талбарт ердийн хар шороон хөрс тархсан гэж үзэж 4 дээж авч, агро хими, эрүүл ахуй, хүнд металлыг тус тус шинжлүүлсэн.

*Хүснэгт 17. Төслийн талбайд дээж авсан цэгийн координат*

| Дээжний дугаар | Координат | |
|---|---|---|
| | Уртраг | Өргөрөг |

| | | |
|---|---|---|
| Зүсэлт – 1 | 104°37' 48.50" | 48°44' 25.95" |
| Зүсэлт – 2 | 104°37' 50.46" | 48°44' 28.14" |

Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнгээр төслийн районд ердийн хар шороон хөрс 2 га талбайд тархсан байна.

*Хүснэгт 18. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл*

| **Хөрсний морфологи бичиглэл** | | |
|---|---|---|
| ***Хөрсний зүсэлтийн дугаар*** | | Зүсэлт-1 |
| ***Өндөр*** | | д.т.д 1152 метр |
| ***Газрын гадарга*** | | $0\text{-}5.6^0$ |
| ***Ургамлын бүрхэвч*** | | 10% |
| ***Хөрсний нэр*** | | Ердийн хар шороон хөрс |
| ***Хөрсний фото*** | *Гүн* | Морфологи шинж чанар |
| | А. 0 -20<br>20 см | Хар хүрэн өнгөтэй, хуурай, нягт, үйрмэг чулуу эзлэхүүний 20%, шилжилт өнгө бага байна.Халтар холимог, цайвар улаандуу бор өнгийн, сийрэг тогтоцтой, улаан өнгийн хэсэг хэсэг шаврանцар, толботой, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, толбогүй хэсгээрээ элсэнцэр, жижиг сайр чулуу-15% |
| **Хөрсний морфологи бичиглэл** | | |
| ***Хөрсний зүсэлтийн дугаар*** | | Зүсэлт-2 |
| ***Өндөр*** | | д.т.д 1151 метр |
| ***Газрын гадарга*** | | $0\text{-}5.6^0$ |
| ***Ургамлын бүрхэвч*** | | 10% |
| ***Хөрсний нэр*** | | Ердийн хар шороон хөрс |
| ***Хөрсний фото*** | *Гүн* | Морфологи шинж чанар |
| | А. 0 -20<br>20 см | Хар хүрэн өнгөтэй, хуурай, нягт, ургамлын үндэс эзлэхүүний 10%, үйрмэг чулуу эзлэхүүний 20%, шилжилт өнгө бага байна.<br>Халтар холимог, цайвар улаандуу бор өнгийн, сийрэг тогтоцтой, улаан өнгийн хэсэг хэсэг шаврանцар, толботой, жижиг бөөмөрхөг бүтэцтэй, толбогүй хэсгээрээ элсэнцэр, жижиг сайр чулуу-15% |

*Хүснэгт 19. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт*

| № | Гүн, см | pH $H_2O$ | ЦДЧ, dS/m | Давс | Ялзмаг % | $CO_2$ | $NO_3$, мг/100 гр | Солилцох сууръ, мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$, | $K_2O$ |
| Зүсэлт – 1 | | | | | | | | | | | |
| 1 | A 0-15 | 7.98 | 0.792 | 0.39 | 2.04 | 0.16 | 1.08 | 11 | 12 | 13 | 14 |
| 2 | AB 15-27 | 8.48 | 0.767 | 0.38 | 0.52 | 3.62 | 0.41 | 11.7 | 4.5 | 2.8 | 12 |
| Зүсэлт - 2 | | | | | | | | | | | |
| 3 | A 0-17 | 7.80 | 1.415 | 0.71 | 3.13 | 0.16 | 1.44 | 15.6 | 5.0 | 3.0 | 63 |

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний А үе нь сул шүлтлэг урвалын орчинтой, АВ үе нь дунд шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж маш бага, хялбар уусах давсны агууламж бага, цахилгаан дамжуулах чадвар бага, карбонатын агууламж бага, нийт нитрат азотын хангамж маш бага, солилцох сууриас Са хангалттай, Mg маш их агууламжтай, хөдөлгөөнт фосфор бага, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин бага байна.

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

*Хүснэгт 20. Хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Дээж авсан гүн, см | Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар | | | | | | | Механик бүрэлдэхүүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Элс | | Тоос | | | | Шавар | |
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 | |
| Зүсэлт – 1 | | | | | | | | | |
| 1 | А 0-15 | 28.0 | 34.2 | 22.3 | 2.0 | 6.5 | 7.0 | 15.6 | Элсэнцэр |
| 2 | АВ 15-27 | 17.7 | 39.4 | 25.2 | 3.9 | 7.8 | 6.1 | 17.8 | Элсэнцэр |
| Зүсэлт – 2 | | | | | | | | | |
| 3 | А 0-17 | 21.2 | 39.8 | 21.4 | 4.3 | 5.9 | 7.4 | 17.6 | Элсэнцэр |

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

*Хүснэгт 21. Хөрсний механик бүрэлдэхүүний шинж чанар*

| Хөрсний шинж чанарын үзүүлэлт | | Механик бүрэлдэхүүн | | |
|---|---|---|---|---|
| | | Элсэнцэр ба хөнгөн шавранцар | Дунд шавранцар | Хүнд шавранцар, шавар |
| 1 | Боловсруулалт | + + | + | - - |
| 2 | Тэжээлийн бодис агуулалт | - - | + | + + |
| 3 | Ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт | - | + + | + |
| 4 | Хоруу бодисын хуримтлал | - | + + | + + |
| 5 | Ус агуулалт | - - | + + | + + |
| 6 | Ургамал ус нийлүүлэлт | - | + | - |
| 7 | Механик шүүлт | + | + | - |
| 8 | Физик-химийн шүүлт | - - | + + | + |
| 9 | Ус шүүлт | + + | 0 | - - |
| *++маш сайн (дээд зэрэг), + сайн (өндөр), 0 хангалттай (дунд зэрэг), - тааруу, - - нэн хангалтгүй | | | | |

Дээрх хүснэгтээс үзэхэд элсэнцэр-хөнгөн шавранцар хөрс нь тэжээлийн бодис, ус агуулалт болон физик химийн шүүлт нэн хангалтгүй, ургамлын тэжээлийн бодис нийлүүлэлт, хоруу бодисын хуримтлал, ургамлын ус нийлүүлэлтээр тааруу харин механик шүүлт сайн, хөрсний боловсруулалт, ус шүүлтээр маш сайн гэсэн үзүүлэлттэй байна.

***Хөрсний бохирдол***

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 1 дээж авч “Инженер Геодези” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 22. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж*

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Нөлөөлөлд өртсөн талбай | <0.05 | 14 | <0.005 | <0.5 | 68 | 25 | 448 |
| | **MNS 5850:2019/ ЗДХ/** | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Хөрсний 1 дээжид хүнд металлын шинжилгээг атомын шингээлтийн спектрометрийн аргаар тодорхойлсон бөгөөд гарсан үр дүнг Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019 стандарттай харьцуулахад Зүсэлт 1-ийн А үе давхаргад хүлцэх агууламжаас даваагүй бохирдолгүй байна.

MNS 5850:2019 стандарт нь хөрс бохирдуулагч бодисуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээний 3 зэрэглэлд хуваадаг. Үүнд:

- Хүлцэх агууламж
- Хортой агууламж
- Аюултай агууламж

*Хүлцэх агууламж:* бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах хэмжээ нь хүлцэх агууламжаас дээш гарсан тохиолдолд хөрс бохирдолтын түвшинд хүрсэн гэж үзнэ. Хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь адил утгатай. Хүлцэх агууламжийг хүн ам оршин суудаг суурин газар, хөдөө аж ахуйн эдэлбэр, газар тариалан, бэлчээрийн эдэлбэр газруудад мөрдлөг болгоно.

*Хортой агууламж:* хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь хортой агууламжаас давсан тохиолдолд тухайн хөрс нь орчин тойронд байгаа амьд организм, усан давхаргад хортой аюул учруулж эхэлнэ. Хортой агууламжийг тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэлийн бүсэд бохирдуулагч бодис, элементийн хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй адил утгаар мөрдлөг болгоно.

*Аюултай агууламж:* хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодис, элементийн хэмжээ нь аюултай агууламжаас давсан тохиолдолд хөрсний бохирдлыг арилгах яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. Тухайлбал саармагжуулах, ухаж зайлуулах, газар ашиглалтын үйл ажиллагааг зогсоох, оршин суугчдыг нүүлгэн шилжүүлэх гэх мэт.

***Хөрсний нянгийн бохирдол***

*Хүснэгт 23.Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт*

| Дээжний дугаар | Нянгийн тоо MNS 6341:2012 | Гэдэсний савханцрын титр MNS 5367:2004 | | Перфрингенсийн таньц MNS 6341:2012 | |
|---|---|---|---|---|---|
| | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| Зүсэлт-4 | $4.4*10^5$ | - | - | - | - |

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад хөрс бага бохирдолтой байна. Хөрсний бохирдол гэдэг нь тухайн хөрсний хэвийн үйл ажиллагаа гадны ямар нэгэн нөлөөгөөр байгалийн шинжээ алдах үйл явцыг хэлнэ. Ерөнхийдөө хөрс нь агаарт цацагдсан хорт бодис, утаа тортог, газар дээрх хуурай нойтон хог хаягдлаар бохирддог. Ялангуяа хүн, амьтны хатуу ба шингэн хаягдал, ургамлын үлдэгдэл, ахуйн ба үйлдвэрийн бохир ус зэрэг нь бохирдуулагч эх үүсвэр болдог байна. Иймд хог хаягдлыг ил задгай хаяхгүй, шатаахгүй байх, хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, хөрс бохирдуулагч жорлон байгуулахгүй байх, хог хаягдлаа шатаахгүй байх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь энгийн хог хаягдлыг орон нутгийн ТҮК-тэй хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээг жил бүр сунган ажиллах шаардлагатай. Мөн нянгийн бохирдол ихтэй газруудад ариутгал халдваргүйжүүлэлт хийх хэрэгтэй

***Усан орчны хяналт шинжилгээний үр дүн***

***Судалгааны байршил***

**Хүснэгт 24. Усны чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил**

| Дээж авсан цэг | | Координат | Худгийн зураг |
|---|---|---|---|
| Худгийн усны дээж авсан хяналтын цэгүүд | | | |
| 1 | Худаг | 104° 37' 51''E<br>48° 44' 27''N | |

***Усан орчны хяналт шинжилгээний үр дүн***

*Худгийн усны химийн задлан шинжилгээний үр дүн*

**Хүснэгт 25. Худгийн усны химийн задлан шинжилгээ**

| Анион | 1дм$^3$ | | | Катион | 1дм$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мг/л | Мг-экв/л | Мг-экв/% | | Мг/л | Мг-экв/л | Мг-экв/% |
| $Cl^-$ | 26.23 | 0.74 | 11.88 | $NA^++K^+$ | 37.18 | 1.62 | 25.98 |
| $SO_4^{2-}$ | 53.90 | 1.12 | 18.04 | $NH_4^+$ | 0.10 | 0.01 | 0.09 |
| $NO_3^-$ | 9.98 | 0.16 | 2.59 | $Ca^{2+}$ | 38.08 | 1.90 | 30.54 |
| $NO_2^-$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Mg^{2+}$ | 32.83 | 2.70 | 43.39 |
| $CO_3^{2-}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $Fe^{2+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $HCO_3^-$ | 256.28 | 4.20 | 67.50 | $Fe^{3+}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| Дүн | 346.39 | 6.22 | 100.00 | Дүн | 108.19 | 6.22 | 100.00 |

Унд ахуйн цэвэр усны нөөцийн савнаас хийсэн ерөнхий химийн шинжилгээний үр дүнг MNS1097:1970 стандартад харьцуулан гаргав. Химийн бүрэлдэхүүн нь гидрокарбонатын анги, магнийн бүлэг, 2-р төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус байна.

***Усан орчны хяналт шинжилгээний дүгнэлт, зөвлөмж***

Төслийн талбай байрлах бүс нутаг нь Монгол орны гадаргын усны ангиллаар Хойд мөсөн далайн ай савд, сав газрын ангиллаар Туул голын сав газарт багтана.

Төслийн талбайн худгийн уснаас 2025 оны 07-р сарын 09-нд авсан усны шинжилгээний үр дүнг MNS1097:1970 стандарттай харьцуулахад усны химийн бүрэлдэхүүн нь гидрокарбонатын анги, магнийн бүлэг, 2-р төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус байна.

Худгийн ус болон технологийн саарал усны дээжийг Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS6148:2010 стандарттай харьцуулахад усан дахь хүнд металлын үзүүлэлт стандартаас даваагүй байна.

Төслийн талбайд зөөврөөр цэвэр усыг нөөцөлж хангадаг бөгөөд ундны усанд байнга шинжилгээ хийж, хяналт тавьж байх шаардлагатай.

ХАВСРАЛТ 2 хөрсний хүнд металлын шинжилгээ

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztl@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2025/395 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг,утас | : "Мөнгөн нуруу" ХХК |
| Сорьц авсан хүний нэр,албан тушаал | : М.Аягул БОШЛ-ийн эрхлэгч |
| Сорьцын тоо,төрөл | : 1 хөрсний сорьц |
| Сорьц авсан огноо | : 2025.07.22 |
| Сорьцын тодорхойлолт | : Сэлэнгэ аймаг Орхонтуул сум |
| Шинжилгээний аргын стандарт | : САЗ А01:2022 |
| Шинжилсэн огноо | : 2025.07.23 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | |
| 1 | Нөлөөлөлд өртсөн талбай | <0.05 | 14 | <0.005 | <0.5 | 68 | 25 | 448 |
| | **MNS 5850:2019/ ЗДХ/** | **3** | **100** | **2** | **150** | **300** | **100** | **800** |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Шинжээч Д.Баярхулан
Хянаж баталгаажуулсан: Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Технологийн саарал усны 7-р сарын 09ны өдөр шинжилгээний хариу

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

**Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983**

MNAS Accreditation system TL 08.01 MNS ISO/IEC 17025

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| | |
|---|---|
| Дугаар он 2025 /У104 | |
| Дээж ирүүлсэн газрын нэр,хаяг,утас | "Мөнгөн нуруу" ХХК |
| Дээжийн тодорхойлолт | Орхонтуул сум |
| Дээж авсан хүний нэр, албан тушаал | БОШЛ-ийн инженер С.Цэнджав |
| Дээжийн тоо, төрөл | 1, Хаягдал усны сорьц |
| Хүлээн авсан огноо | 2025 он 07 дугаар сарын 08 |
| Сорилтын арга, аргачлал | MNS ISO 10523:2001, MNS 1097:2023<br>MNS 6779:2019, MNS 6834:2020<br>MNS 6833:2020, MNS ISO 6878:2001<br>MNS ISO 5815:2015, MNS ISO 6060:2001<br>MNS 6836:2020 |
| Дээжийн тодорхойлсон үзүүлэлт | биогены үзүүлэлт |
| Шинжилгээ хийж дууссан огноо | 2025 он 07 дугаар сарын 09 |

**ХАЯГДАЛ УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

| Шинжилгээний үзүүлэлтүүд, нэгж | 7 дугаар сар | MNS 4943:2015 |
|---|---|---|
| | Гаралтын ус | |
| PH –орчин | 8.51 | 5-9 |
| Аммоны азот, мгN/л | 2.46 | 15 |
| Нитрит, мгN/л | 0.640 | |
| Нитрат, мгN/л | 3.46 | |
| Сульфат, мг/л | 390.1 | |
| Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч мгO/л | **369.7** | 20 |
| Химийн хэрэгцээт хүчилтөрөгч мгO/л | **2976.0** | 50 |
| Жинлэгдсэн бодис (умбуур бодис), мг/л | **242.6** | 30 |
| Өнгө | 71.68 | - |
| Перманганатын исэлдэх чанар | 11.1 | |

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт байрлах "Мөнгөн нуруу" ХХК-ний хаягдал уснаас дээж авч химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 4943:2015 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс жинлэгдсэн бодис 8.09 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 18.48 дахин, химийн хэрэгцээт хүчилтөрөгч 59.52 дахин давсан байлаа.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер М.Өнөржаргал
Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн ерөнхий инженер М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Худгийн усны ерөнхий хими

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

**Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036- 3983**

MNAS Accreditation system TL 08-01 MNS ISO/IEC 17025

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он 2025 / № У103

| | |
|---|---|
| Дээж ирүүлсэн газрын нэр,хаяг,утас | "Мөнгөн нуруу" ХХК |
| Дээжийн тодорхойлолт | Орхонтуул сум |
| Дээж авсан хүний нэр, албан тушаал | БОШЛ-ийн инженер С.Цэнджав |
| Дээжийн тоо, төрөл | 1, Ундны ус |
| Хүлээн авсан огноо | 2025 - 07- 08 |
| Дээжийн тодорхойлох үзүүлэлт | гол ион, биогений элемент |
| Шинжилгээ хийж дууссан огноо | 2025 – 07 - 21 |

| Стандартын дугаар | Шинжилгээ хийсэн элементүүд | Цайны газрын ус | MNS 900:2018 |
|---|---|---|---|
| MNS ISO 10523:2001 | PH –орчин | 7.94 | 6.5-8.5 |
| САЗ У 21:2012 | Өнгө | - | 20 градус |
| MNS 1097:2023 | Кальци, мг/л | 65.2 | 100.0 |
| MNS 1097:2023 | Магни, мг/л | 28.8 | 30.0 |
| MNS 1097:2023 | Аммоны азот, мгN/л | 0.04 | 1.5 |
| MNS 4430:2005 | Төмөр /нийт/, мг/л | 0.02 | 0.3 |
| MNS 9297:2005 | Хлор, мг/л | 11.3 | 350.0 |
| MNS 6271:2011 | Сульфат, мг/л | 106.2 | 500.0 |
| MNS 6779:2019 | Нитрит, мгN/л | 0.001 | 1.0 |
| MNS 6834:2020 | Нитрат, мгN/л | 0.74 | 50.0 |
| MNS 6831:2020 | Гидрокарбонат | 408.8 | |
| MNS ISO 6059:2005 | Хатуулаг, мг-экв/л | 5.62 | 7.0 |
| MNS 6833:2020 | Перманганатын исэлдэх чанар, мгО/л | 0.4 | |
| MNS 6272:2011 | Фтор, мг/л | 0.19 | 0.7-1.5 |
| MNS 1097:2023 | Эрдэсжилт, мг/л | 710.6 | |
| САЗ У 20:2012 | Na+K, мг/л | 90.0 | |
| MNS ISO 6878:2001 | Фосфор, мг/л | 0.050 | 3.5 |
| MNS ISO 7888:1999 | EC, µs/cm | 2260.0 | 1000.0 |
| | Булингар, FNU | 5.56 | 5.0 |
| MNS 6835:2020 | Цахиур, мг/л | 6.4 | |
| MNS ISO 11083:2001 | Хром+6, мг/л | Илрээгүй | |

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт байрлах "Мөнгөн нуруу" ХХК-ний цайны газрын усанд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 900:2018 стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт үгүй байна.

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..................М.Өнөржаргал

Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн эрхлэгч..................М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Хөрсний хяналт шинжилгээний хүрээнд 7-р сарын дээжлэлт

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

**Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983**

MNAS Accreditation system
TL 08-01
MNS ISO/IEC 17025

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

| | |
|---|---|
| Дугаар он | 2025 / Х53-54 |
| Дээж ирүүлсэн газрын нэр,хаяг,утас | "Мөнгөн нуруу" ХХК |
| Дээжийн тодорхойлолт | Орхонтуул сум |
| Дээж авсан хүний нэр, албан тушаал | БОШЛ-ийн инженер С.Цэнджав |
| Дээжийн тоо, төрөл | 2, Хөрс |
| Хүлээн авсан огноо | 2025 – 07 – 08 |
| Дээжийн тодорхойлох үзүүлэлт | агрохимийн үзүүлэлт |
| Шинжилгээний аргын стандарт | MNS 3310:1991 |
| Шинжилгээ хийж дууссан огноо | 2025 – 07 - 21 |

**ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

| № | Дээж авсан цэгийн нэр | Тодорхойлсон элементүүд мг/кг | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | PH | Чийг % | Нитрат | Фосфор | Аммони азот | ялзмаг | EC, µs/cm | Сульфат |
| 1 | Кемп | 8.07 | 1.13 | 12.0 | 13.20 | 74.5 | 2.2 | 25.2 | 112.8 |
| 2 | Нөлөөлөлд өртсөн газар | 9.14 | 1.02 | 8.9 | 21.03 | 75.9 | 0.8 | 42.4 | 97.4 |
| MNS 3297:2019 стандарт дахь /ЗДХ/ | | 6-9 | - | 130.0 | - | - | - | - | 160.0 |

Шинжилгээ хийсэн: БОШЛ-ийн инженер..............................С.Цэнджав
Шинжилгээг хянасан: БОШЛ-ийн эрхлэгч..............................М.Аягул

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08-01

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Агаарын дээжний хариу

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

**Сүхбаатар сум, Цагаан эрэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН**

Дугаар он 2025 /А73-74

| | |
|---|---|
| Дээж ирүүлсэн газрын нэр,хаяг,утас | "Мөнгөн нуруу" ХХК |
| Дээжийн тодорхойлолт | Орхонтуул сум |
| Дээж авсан хүний нэр, албан тушаал | БОШЛ-ийн инженер С.Цэнджав |
| Дээжийн тоо, төрөл | 2, Агаарын дээж |
| Хүлээн авсан огноо | 2025 – 07 - 08 |
| Сорилтын арга, аргачлал | MNS 0017-2-5-12:2021<br>MNS 0017-2-5-11:2021<br>MNS4048-88 |
| Дээжийн тодорхойлсон үзүүлэлт | хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос |
| Шинжилгээ хийж дууссан огноо | 2025 – 07 - 09 |

**АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

| № | Хэмжилт хийсэн цэгийн нэр | Тодорхойлсон элементүүд, мг/м3 | |
|---|---|---|---|
| | | Азотын давхар исэл (NO2) | Хүхэрлэг хий (SO2) |
| 1 | Кемп | 0.025 | 0.004 |
| 2 | Олборлолтын талбай орчим | 0.031 | 0.007 |
| MNS4585:2025 стандарт дахь хүлцэх агууламж | | **0.200** | **0.450** |

| № | Хэмжилт хийсэн цэгийн нэр | Тодорхойлсон элементүүд | | |
|---|---|---|---|---|
| | | Нийт тоос, мг/м3 | | |
| | | Дундаж | Хамгийн их | Хамгийн бага |
| 1 | Кемп | 0.078 | 0.823 | 0.046 |
| 2 | Олборлолтын талбай орчим | 0.338 | 7.86 | 0.058 |
| MNS4585:2025 стандарт дахь хүлцэх агууламж | | **0.500** | - | - |

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт байрлах "Мөнгөн нуруу" ХЖК-ны уурхайн орчмоос агаарын дээж авч химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 4585:2025 стандарт дахь хүлцэх агуулламжаас давсан үзүүлэлтгүй байна.

Шинжилгээ хийсэн. БОШЛ-ийн инженер.............................................С.Цэнджав
Шинжилгээг хянасан. БОШЛ-ийн эрхлэгч.............................................М.Аягүл

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ TL 08-01

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

## АРВАН ГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Биелэлтийн үр дүн |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг хугацаандаа танилцуулах, батлуулах | - | 2025 онд БОМТ батлуулсан. Хавсралтаар баталсан нүүрийг оруулав. |
| | Нийт | - | |

## АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН

**БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| № | БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Биелэлтийн үр дүн | Тайлагнах зардал, төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | 2025 оны БОМТөлөвлөгөөг танилцуулах, батлуулах | Цахим, цаасан | Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө | 2025.03 | - | Гүйцэтгэх захирал | БОУАӨЯ |
| 2. | БОМТ-ны дагуу хийгдсэн ажлыг тайлагнах | Цахим, цаасан зургаар | Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг тайлагнах | 2025.11 | - | Гүйцэтгэх захирал | БОУАӨЯ |
| | Нийт | | | | - | | |

**Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 88.7 сая төгрөг**

**“НОГООН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ” ХХК**

Монгол улс, Улаанбаатар хот,
Баянгол ä¿¿ðýã, 11 дүгээр хороо,
Хувьсгалын гудамж /16060/, 36-р байр
4 дүгээр давхар, 14 тоот
Утас: (976)-77030503, Факс: (976)-77030503
Гар утас: (976)-88010503, (976)-91040503
Web: www.en-audit.mn
E-mail: d.batbold@yahoo.com

2025.09.08 № 01/261

Танай__________ны №__________-т

“МӨНГӨН НУРУУ” ХХК-Д

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын
дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

**Удиртгал:**

“Ногоон гэрэлт ирээдүй” ХХК болон “Мөнгөн Нуруу” ХХК-ийн хооронд 2025 оны 8-р сарын 18-ны өдрийн №2025/014 тоот “Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийх, ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших MV-022165 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Дэнж нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаанд нийцлийн болон гүйцэтгэлийн аудитыг “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-ийн Байгаль орчны аудитын баг Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийн $10^1$ зүйлийн дагуу, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар 25-ны өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал” болон компанийн өөрийн боловсруулсан нарийвчилсан арга зүйг мөрдлөг болгон ажиллав. Аудитын үр дүнг үнэлэхдээ нийцэл, үл нийцэл, сайжруулах шаардлагатай болон хугацаа болоогүй гэсэн 4 үнэлэмжийг ашигласан.

Аливаа нотолгоогоор гүйцэтгэл нь батлагдсан тохиолдолд нийцэл, батлагдаагүй тохиолдолд үл нийцэл, хууль эрх зүйн хүрээнд болон гүйцэтгэлийн шатанд үр дүн нь тодорхойлогдох болоогүй эсвэл тухайн шалгуур бодит шалтгааны улмаас гүйцэтгэл нь түр хойшлогдсон тохиолдолд хугацаа болоогүй гэсэн үнэлэмжид хамааруулав.

**Аудитын зорилго:**

“Мөнгөн нуруу” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших MV-022165 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Дэнж нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл”-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийгдсэнээр байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй аргаар үйлдвэрлэл явуулахад туслах, тэднийг учирч болох алдагдал, хохирлоос урьдчилан сэргийлэх үүднээс байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчны

нөлөөллийн үнэлгээний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэл, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөхөд аудитын зорилго оршино. Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 8 чиглэлд хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Хуулийн нийцэл;
2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, мониторингийн ажлын гүйцэтгэл
    - 2.1. Усан орчны менежмент;
    - 2.2. Агаар орчны менежмент;
    - 2.3. Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент;
    - 2.4. Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент;
    - 2.5. Биологийн олон янз байдлын менежмент;
    - 2.6. Хог хаягдлын менежмент;
        - 2.6.1. Ахуйн хог хаягдал
        - 2.6.2. Аюултай хог хаягдал зэрэг болно.

**Аудитын төрөл:**

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг үндсэн 2 чиглэлээр гүйцэтгэсэн. Үүнд:

1. Байгаль орчны нийцлийн аудит
2. Байгаль орчны гүйцэтгэлийн аудит зэрэг болно.

**Аудитын хамрах хүрээ:**

Тус аудитад дараах зүйлс хамрагдсан. Үүнд:

<u>Цаг хугацааны хувьд:</u> Нийт 21 хоног

<u>Орон зайн хувьд:</u> Уурхайн үйл ажиллагаа

<u>Бичиг баримтын хувьд:</u> Үйлчлүүлэгч байгууллагаас хангасан бичиг баримтуудын хүрээнд ажилласан. Гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, аудитын шалгуурт тооцоогүй.

<u>Объектын хувьд:</u> Уурхайн бүхэлдээ

<u>Хууль тогтоомжийн хүрээнд:</u> Монгол Улсын хууль тогтоомж болон стандартыг аудитын шалгуур тогтооход ашигласан. Байгаль орчны багц хуулиудын томоохон өөрчлөлтүүд 2012 оны 5 дугаар сард орж, 2012 оны 6 дугаар сараас хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аудитын үйл ажиллагааны хууль тогтоомжийн хүчин төгөлдөржилтийн цаг хугацааны хамрагдалт нь 2012 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаагаар хязгаарлахаар тохиролцсон. Энэ удаагийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит нь 2025 оны 8 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгохгүй. Гэхдээ аудит хийлгэгч байгууллагын аливаа үйл ажиллагааг тухайн үед хүчин төгөлдөр байсан хууль тогтоомжтой харьцуулах ба үйл ажиллагааг хийснээс хойш бий болсон хууль тогтоомжийн шалгууртай харьцуулж үнэлэмжийг гаргаагүй болно.

<u>Хуулийн этгээдийн хүрээнд:</u> Зөвхөн үйлчлүүлэгч байгууллагын хүрээнд хийгдэх ба туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгч байгууллагад аливаа бараа

материал нийлүүлдэг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагаа хамаарахгүй ба тухайн байгууллагын үйлчлүүлэгчид нийлүүлсэн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний гэрээ, бичиг баримтын бүрдэл, нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний тайлан гэх мэтийг үзээгүй. Дээрх зүйлст аливаа үл нийцэл илэрвэл түүнийг цаашлуулан гэрээлэгч байгууллагад аудит хийгээгүй тул зөвхөн үл нийцлийг тайландаа тусгаж, түүнд аудит хийлгэхийг зөвлөмж хэлбэрээр оруулж болно.

**Аудитад хамрагдаагүй хэсэг:**

Тус аудитад дараах зүйлс хамрагдаагүй. Үүнд:

<u>Цаг хугацааны хувьд:</u> Газар дээрх аудит хийснээс хойш хугацаанд болсон аливаа үйл ажиллагаа

<u>Орон зайн хувьд:</u> Уурхайн үйл ажиллагаанаас өөр газарт болсон аливаа үйл ажиллагаа

<u>Бичиг баримтын хувьд:</u> Гуравдагч этгээдээс бичиг баримт аваагүй, аудитын шалгуурт тооцоогүй.

<u>Объектын хувьд:</u> Уурхайн үйл ажиллагаа болон туслах үйл ажиллагаанд хамааралгүй аливаа объект

<u>Хууль тогтоомжийн хувьд:</u> 2025 оны 8 дугээр сарын 01-ний өдрөөс хойших аливаа хууль тогтоомжийн өөрчлөлт, нэмэлт, шинэчлэл зэрэг нь аудитын шалгуурт хамаарахгүй. Түүнчлэн хүчингүй болсон хууль тогтоомжийн аливаа зүйл заалтыг шалгуур болгоогүй.

<u>Хуулийн этгээдийн хүрээнд:</u> Үйлчлүүлэгчээс бусад этгээд хамаарахгүй, мөн үйлчлүүлэгчийн туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, бусад гэрээт ажил гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанд аудит хийгээгүй.

**Аудитын шалгуур:**

Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг гүйцэтгэхэд ашигласан үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд төслийн техник эдийн засгийн үндэслэл, шийдвэр, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний хэрэгжилт, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлт, өмнө нь гүйцэтгэсэн байгаль орчны аудитын тайлан болон хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, норм, норматив, эрхийн актууд, зөвшөөрөл, гэрээ, дүгнэлтэд үндэслэсэн болно.

Байгаль орчны төлөвлөгөөт аудитын хүрээнд нийт 686 шалгуур үзүүлэлтээр байгаль орчны аудитыг гүйцэтгэв. Эдгээрээс 181 нь хамааралгүй, 272 нь хуулийн нийцэл, 31 нь төрийн бодлого, үндэсний хөтөлбөр, 428 нь үндэсний хууль тогтоомж, 175 нь холбогдох дүрэм журам, аргачлал, 52 нь стандартад давхардсан байдлаар тусгалаа олсон болно.

*Хүснэгт 1. Байгаль орчны аудитын шалгуур үзүүлэлт*

| № | Үзүүлэлт | Хуулийн нийцэл | Усан орчин | Агаар орчин | Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлт | Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлт | Биологийн олон янз байдал | Ахуйн хог хаягдал | Аюултай хог хаягдал | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн бодлого, үндэсний хөтөлбөр | 0 | 9 | 5 | 3 | 2 | 1 | 9 | 2 | **31** |
| 2. | Үндэсний хууль тогтоомж | 272 | 37 | 11 | 10 | 10 | 7 | 35 | 46 | **428** |
| 3. | Дүрэм, журам, аргачлал | 0 | 64 | 7 | 8 | 13 | 8 | 32 | 43 | **175** |
| 4. | Стандарт | 0 | 12 | 10 | 9 | 8 | 0 | 7 | 6 | **52** |
| | **Нийт дүн** | **272** | **122** | **33** | **30** | **33** | **16** | **83** | **97** | **686** |
| | **Үүнээс:** | | | | | | | | | |
| | Нийцэл | 235 | 100 | 11 | 10 | 15 | 8 | 45 | 61 | **485** |
| | Сайжруулах шаардлагатай | 0 | 1 | 1 | 2 | 2 | 1 | 5 | 4 | **16** |
| | Үл нийцэл | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 3 | **4** |
| | Хамааралгүй | 36 | 21 | 21 | 18 | 16 | 7 | 33 | 29 | **181** |
| | **Нийт дүн** | **272** | **122** | **33** | **30** | **33** | **16** | **83** | **97** | **683** |

**Аудитын үнэлэмж:**

Шалгуур бүрийг нотолгоотой уялдуулан үнэлэмжийг боловсруулсан. Нийт нийцлийн болон гүйцэтгэлийн 686 шалгуурыг цуглуулсан нотолгоонууд дээр тулгуурлан үнэлэмжийг боловсруулахад дараах байдлаар үнэлэгдэв. Шалгуур үзүүлэлтийн хувийг тооцохдоо хамааралгүй гэсэн үзүүлэлтийг хасаж тооцсон болно.

Аудитын үр дүнгийн үнэлэмжийн бүртгэл:

- ❖ Нийцэл 485
- ❖ Сайжруулах шаардлагатай 16
- ❖ Хугацаа болоогүй 0
- ❖ Үл нийцэл 4
- ❖ Хамааралгүй 181

Үнэлэмжийн бүтцийг дараах графикт үзүүлэв.




*График 1. Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын үнэлэмжийн бүтэц*

**БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭЛ:**

Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журам, стандарт шаардлагын дагуу бэлтгэсэн 686 асуулга бүхий ажлын маягтуудыг ашигласан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлсэн байдлын үнэлгээ (нийцэл /хангалттай/, тодорхойгүй /үнэлэх боломжгүй/, хугацаа болоогүй /ирээдүйд хийгдэх/, үл нийцэл /хангалтгүй/, хамааралгүй)-г нэгтгэн дараах хүснэгтэд үзүүлэв. Шалгуур үзүүлэлтийн хувийг тооцохдоо хамааралгүй гэсэн үзүүлэлтийг хасаж тооцсон болно.

*Хүснэгт 2. Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэл*

| № | Байгаль орчны аудитын хамрах хүрээ | Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын шалгуур үзүүлэлт | | | | | Хэсгийн дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийцэл /хангалттай/ | Сайжруулах шаардлагатай /цаашид | Хугацаа болоогүй /ирээдүйд | Үл нийцэл /хангалтгүй/ | Хамааралгүй | |
| 1. | Хуулийн нийцэл | 235 | 0 | 0 | 1 | 36 | **272** |
| 2. | Усан орчны менежмент | 100 | 1 | 0 | 0 | 21 | **122** |
| 3. | Агаар орчны менежмент | 11 | 1 | 0 | 0 | 21 | **33** |
| 4. | Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент | 10 | 1 | 0 | 0 | 18 | **30** |
| 5. | Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент | 15 | 2 | 0 | 0 | 16 | **33** |
| 6. | Биологийн олон янз байдлын менежмент | 8 | 1 | 0 | 0 | 7 | **16** |
| 7. | Хог хаягдлын менежмент | | | | | | |
| 7.1 | - Ахуйн хог хаягдал | 45 | 5 | 0 | 0 | 33 | **83** |
| 7.2 | - Аюултай хог хаягдал | 61 | 4 | 0 | 3 | 29 | **97** |
| **Нийт** | | **485** | **16** | **-** | **4** | **181** | **686** |
| **Эзлэх хувь /%/** | | **96.0** | **3.2** | **-** | **0.8** | **-** | **100** |

Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 686 асуулгын 485 (96.0%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 16 (3.2%) асуулгад сайжруулах шаардлагатай, 4 (0.8%) асуулгад үл нийцэл, харин 181 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна.

*Хүснэгт 3. Байгаль орчны аудитын үл нийцлийн эрсдэлийн нэгтгэл*

| № | Байгаль орчны аудитын хамрах хүрээ | Үл нийцлийн эрсдэл | | | | Хэсгийн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| | | Их | Дунд | Бага | Үгүй | |
| 1. | Хуулийн нийцэл | 0 | 0 | 1 | 235 | **272** |
| 2. | Усан орчны менежмент | 0 | 0 | 1 | 100 | **122** |
| 3. | Агаар орчны менежмент | 0 | 0 | 1 | 11 | **33** |
| 4. | Хөрсөн бүрхэвч ба техникийн нөхөн сэргээлтийн менежмент | 0 | 0 | 2 | 10 | **30** |
| 5. | Ургамлан нөмрөг ба биологийн нөхөн сэргээлтийн менежмент | 0 | 0 | 2 | 15 | **33** |
| 6. | Биологийн олон янз байдлын менежмент | 0 | 0 | 1 | 8 | **16** |
| 7. | Хог хаягдлын менежмент | | | | | |
| 7.1 | - Энгийн хог хаягдлын менежмент | 0 | 0 | 5 | 45 | **83** |
| 7.2 | - Аюултай хог хаягдлын менежмент | 0 | 0 | 7 | 61 | **97** |
| | **Нийт** | **-** | **-** | **20** | **485** | **505** |
| | **Эзлэх хувь /%/** | **-** | **-** | **4.0** | **96.0** | **100** |

Байгаль орчны аудитын эрсдэлийн нэгтгэлээс үзэхэд нийт 505 асуулгын 485 (96.0%) асуулгад эрсдэл байхгүй, 20 (4.0%) асуулгад бага зэрэг эрсдэл үүсэж болзошгүй байгааг цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай.

**Аудитын ерөнхий дүгнэлт:**

"Мөнгөн нуруу" ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших MV-022165 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Дэнж нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн Байгаль орчны төлөвлөгөөт аудит гүйцэтгэсэн үр дүнг үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Байгаль орчны аудитын үр дүнгийн нэгтгэлээс үзэхэд нийт 686 асуулгын 485 (96.0%) асуулгад хангалттай буюу хэрэгжилт маш сайн гэсэн үнэлгээ авсан бол нийт 16 (3.2%) асуулгад сайжруулах шаардлагатай, 4 (0.8%) асуулгад үл нийцэл, харин 181 асуулгад хамааралгүй гэсэн үнэлэмжийг авсан бол тодорхойгүй буюу үнэлэх боломжгүй асуудал гараагүй байна. Байгаль орчны аудитын үр дүн 96.0%-тай байгаагаас дүгнэхэд уурхайн үйл ажиллагааны хуулийн нийцэл болон гүйцэтгэлийн үр дүн **"Маш сайн"** байгааг харуулж байна.
2. "Мөнгөн нуруу" ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших MV-022165 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Дэнж нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл"-ийн байгаль орчны үйл ажиллагааны 96.0% нь үндэсний хууль тогтоомжид нийцтэй буюу гүйцэтгэлтэй байна. Хугацаа болоогүй буюу тухайн шалгуурыг гүйцэтгэх цаг

хугацаа болоогүй байгаа тул тэдгээрийг шууд үл нийцэл гэж ойлгохгүй бөгөөд тус байгууллага ирээдүйд түүнийг гүйцэтгэнэ гэдэг итгэлтэй байна. Үл нийцэл нь 0.8% байна. Сайжруулах шаардлагатай буюу аудитын явцад хангалттай мэдээ баримт цуглаагүй, аудит хийлгэгч талаас нотлох баримтаар хангаагүй шалгууруудыг дараагийн төлөвлөгөөт аудит гүйцэтгэх хүртэл хугацаанд нийцэлтэй болгож залруулах боломжтой.

3. Байгаль орчны аудитын эрсдэлийн нэгтгэлээс үзэхэд нийт 505 асуулгын 485 (96.0%) асуулгад эрсдэл байхгүй, 20 (4.0%) асуулгад бага зэрэг эрсдэл үүсэж болзошгүй байгааг цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн А/809 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал"-ын дагуу дүгнэвэл: Тус байгууллагын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, үр дагавар онц уршигтай бус бөгөөд удирдлага, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ болон хууль тогтоомжийн зохих заалтуудыг хангах шаардлагатай. Цаашид сайжруулах шаардлагатай гарсан шалгууруудыг нийцэлтэй болгохын тулд амлалтын хугацаа тогтоож, холбогдох хүмүүст үүрэг ногдуулах хэрэгтэй. Төслийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжтой.
5. Уурхайн "Сайжруулах шаардлагатай", "Үл нийцэл" гэж үнэлэгдсэн шалгууруудыг тус компани өөрийн амлалтын хугацаанд залруулах боломжтой ба түүнийхээ биелэлтийг дотоод шалгалтаараа гаргаж, биелэлтийн тайланг Монгол Улсын "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн $10^1$ дүгээр зүйлийн 1-р заалтыг үндэслэн Сэлэнгэ аймгийн Байгаль хамгаалах газарт жил бүрийн 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор хүргүүлнэ.

**Ерөнхий зөвлөмж:**

Аудит хийгдсэн үндсэн 8 чиглэл тус бүрийн зөвлөмжүүд тайлангийн үл нийцлийг арилгах төлөвлөгөөнд туссан бөгөөд "Мөнгөн Нуруу" ХХК-ийн зүгээс дараагийн аудитыг хийлгэхдээ чиглэлээ улам өргөжүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Байгаль орчны багц хууль 2012 онд шинэчлэгдэн батлагдсан, тэдгээрийг биелүүлэх журмууд 2012-2025 онуудад батлагдан гарч байгаа бөгөөд тус компанийн хувьд эдгээр журмын заалтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Аливаа хийсэн ажлыг баримтжуулах, түүнийг архивлан хадгалах асуудлыг анхааралдаа авч, үүнийг байгаль орчны мэргэжилтэнд бүрэн хариуцуулах хэрэгтэй.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ
АХЛАХ АУДИТОР /Д.БАТБОЛД/

УЛААНБААТАР ХОТ ... ЭРЭЛТ ИРЭЭДҮЙ ХХК ... ТТ38077...

UFC

**ГОЛОМТ БАНК**

## ТӨЛБӨРИЙН БАРИМТ / APPLICATION FOR REMITTANCE

=16,437,500.00=

| Он сар өдөр | Дүн / Amount | Үсгээр / In words |
|---|---|---|
| 2025 6 10 | Мөнгөний нэгж / Currency: ✓ MNT ☐ USD ☐ Бусад | (АРВАН ЗУРГААН САЯ ДӨРВӨН ЗУУН ГУЧИН ДОЛООН МЯНГА ТАВАН ЗУУН ТӨГРӨГ) |
| ХЭНЭЭС / FROM | Дансны нэр / Account name: МӨНГӨН НУРУУ ХХК | Төлбөрийн зориулалт / Details of payment: МӨНГӨН НУРУУ ХХК РД-6470556 НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГААНЫ ТӨЛБӨР |
| | Дансны дугаар / Account No: IBAN: MN51001500 3 4 0 5 1 2 4 1 2 7 | |
| ХЭНД / TO | Банкны нэр / Bank name: ТӨРИЙН САН | Гарын үсэг / Signature: 1st, 2nd — Тамга / Stamp |
| | Дансны нэр / Account name: БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА | |
| | Дансны дугаар / Account No: IBAN: MN78009010 1 0 0 9 0 0 0 1 3 4 0 6 | |

**ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE ONLY**

ХҮА / TELLER:

Хянасан / Verified by:

Он / сар / өдөр / YYYY / MM / DD

**ТЭМДЭГЛЭЛ / NOTE:**

Шилжүүлэх данс: 3405124127

Хүлээн авах данс: 100900013406

Хүлээн авах дансны нэр:

Хүлээн авагчийн банк:

Мөнгөн дүн: 16,437,500

---

**TDB — ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК**

## ДОТООД ШИЛЖҮҮЛГИЙН МАЯГТ / TRANSFER SLIP

Мөнгөн нуруу ххк 6470556 MV-22165

| ОН/YEAR | САР/MONTH | ӨДӨР/DAY | ЦАГ / TIME | ЖУРНАЛ ДУГААР / JOURNAL № | МӨНГӨНИЙ ДҮН (тоогоор) / AMOUNT (in figure) | МӨНГӨНИЙ НЭГЖ / CURRENCY |
|---|---|---|---|---|---|---|
| 2025 | 05 | 05 | 11:20:03 | 925600637220 | 12,097,500.00 | MNT |

**ХААНААС: / FROM:**

ДАНС ЭЗЭМШИГЧИЙН НЭР / ACCOUNT HOLDER'S NAME: МӨНГӨН Нуруу Ххк

ДАНСНЫ ДУГААР / ACCOUNT №: 452648284

РЕГИСТРИЙН № / PERSONAL ID №: 6470556

МӨНГӨНИЙ ДҮН (үсгээр) / AMOUNT (in words): АРВАН ХОЁР САЯ ЕРЭН ДОЛООН МЯНГА ТАВАН ЗУУН ТӨГРӨГ

**ХЭНД: / TO:**

ХҮЛЭЭН АВАГЧ БАНК / BENEFICIARY'S BANK: Төрийн сан

ХҮЛЭЭН АВАГЧИЙН ОВОГ, НЭР / BENEFICIARY'S FULL NAME: БО Нөхөн Сэргээх Баталгаа

ДАНСНЫ ДУГААР, МӨНГӨНИЙ НЭГЖ / ACCOUNT №, CURRENCY: 100900013406 MNT

ШИМТГЭЛ / FEE: 400.00

ТӨЛБӨРИЙН ЗОРИУЛАЛТ / PAYMENT DETAILS: МӨНГӨН НУРУУ ХХК 6470556 MV-022165 БО нөхөн сэргээх баталгаа 2025

**ТЭМДЭГЛЭЛ: / NOTE:**

ЗАРЛАГА ГАРАХ ДАНСНЫ ДУГААР, МӨНГӨН ДҮН / SEND ACCOUNT №, AMOUNT: 452648284 12,097,500

ХҮЛЭЭН АВАГЧИЙН БАНК, ОВОГ НЭР, ДАНСНЫ ДУГААР, ДАНСНЫ ВАЛЮТ / BENEFICIARY'S BANK, FULL NAME, ACCOUNT NUMBER, CURRENCY: 100900013406 БО нөхөн сэргээх баталгаа Төрийн сан 2025

ТАМГА / STAMP, IF ANY

БАТАЛГААТ ГАРЫН ҮСЭГ / AUTHORIZED SIGNATURE: 1st, 2nd

САНАМЖ / NOTICE: Харилцагчийн буруугаас шилжүүлэг буцаж тохиолдолд буцааж авах хариуцлага банк хүлээхгүй болно.

**ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE**

ХӨРВҮҮЛСЭН ХАНШ: 1.00 — 12,097,500.00

ХҮЛЭЭН АВСАН БАНКНЫ АЖИЛТАН: 7610

ХӨРВӨСӨН ДҮН:

ХЯНАСАН:

| Он | Сар | Өдөр |
|---|---|---|
| 2025 | 05 | 05 |

Маягт - 004

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА — Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"МӨНГӨН НУРУУ" ХХК ЗАХИРАЛ — Л.ГАНСҮХ

# "МӨНГӨН НУРУУ" ХХК НИЙ СЭЛЭНГЭ АЙМАГ, ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИНЭ. "ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ" ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-022165
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6470556

ХЯНАСАН:
ХБОБЗГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ — З. ЦОГТБАЯР

БОЛОВСРУУЛСАН:
"МӨНГӨН НУРУУ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН — Х.ЗУЛСАР

2025 ОН

# ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙГ НЬ ГАЗАРТ БЭХЭЛСЭН НЭГЖ ТАЛБАРЫН ЗУРАГ

**Нэгж талбарын дугаар:**
**Газар эзэмшигчийн овог нэр: Мөнгөн нуруу ХХК**
**Регистерийн дугаар: 6470556**
**Хаяг: Сэлэнгэ аймаг Орхонтуул сум**



нэгж талбар

| № | N | E |
|---|---|---|
| 1 | 49'24'02.40 | 107'20'56.20 |
| 2 | 49'23'59.00 | 107'20'54.40 |
| 3 | 49'24'04.50 | 107'20'48.00 |
| 4 | 49'24'01.80 | 107'20'45.60 |

| № | N | E |
|---|---|---|
| 1 | 49°23'53.20 | 107°21'10.30 |
| 2 | 49°23'54.50 | 107°21'12.30 |
| 3 | 49°23'47.30 | 107°21'23.10 |
| 4 | 49°23'46.20 | 107°21'21.30 |

**Эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбилцуулсан үндэслэлийн цэг.**
**Цэгийн солбилцол 1: X......................Y..................H................**
**Цэгийн солбилцол2: X......................Y..................H................**
**Цэгийн солбилцол3: X......................Y..................H................**

**Талбайн хэмжээ: 3га**

**Хэмжилт үйлдсэн:**
**Огноо:**

**ЭДЛЭН ГАЗРЫН УЛСЫН ТОО БҮРТГЭЛИЙН ХУУДАС №....**

1.Хуулийн этгээд (Холбогдох дугаарыг дугуйлна уу

1.Иргэн ②ААН 3.Байгууллага 4.Гадаад иргэн 5. Гадаад ААН 6. Гадаад байгууллага

2.Иргэний овог, эцэг эхийн нэр, ААН, байгууллагын нэр: Мөнгөн нуруу ХХК

3.Регистрийн дугаар: 6470556

4.Иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн дугаар: 9011811159

5.Байнгын хаяг: Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум

6.Утас:99109815 7.Аймаг/Нийслэл (доогуур нь зур) 8.Дүүрэг 9.Хорооны дугаар 10.Гудамжны нэр 11.Байшин, хашааны дугаар

12.Газар ашиглах хэлбэр (холбогдох дугаарыг дугуйлна уу)

1.өмчлөх 2.эзэмших 3.ашишлах

13.Зөвшөөрөл олгосон байгууллагын нэр 14.Гэрчилгээний дугаар:000190539

15.Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар: 16.Огноо 17.Гэрээний дугаар

18.Гэрээ байгуулсан огноо 19.Талбайн хэмжээ (кв.м)

20.Газар эзэмших (ашиглах) хугацаа (жил)

21.Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 22.Огноо

23.Газар дээр байгаа барилга, объектийн мэдээлэл

24.Зориулалт (холбогдох дугаарыг дугуйлна уу)

1. Иргэний ахуйн
2. Албан контор
3. Боловсрол
4. Эрүүл мэнд
5. Спорт
6. Соёл урлаг
7. Аж ахуйн хашаа агуулах
8. Нийтийн тээвэр
9. Холбоо эрчим хүч, шугам сүлжээ
10. Төмөр зам
11. Нисэх онгоцний буудал
12. Худалдаа бүх төрлийн үйлчилгээ
13. Нам, олон нийтийн
14. Шашны
15. Гарааш
16. Шатахуун түгээх станц, нефтийн агуулах
17. Үйлдвэрлэл
18. Эрдэс баялаг, элс, хайрга шороо
19. Газар тариалан
20. Хүлэмжийн аж ахуй
21. Төмс хүнсний ногоо, жимсний талбай
22. Фермер
23. Төрийн
24. Хувийн

**Эдлэн газрын улсын тоо бүртгэлийн хуудас бөглөсөн:**

25.Иргэн, ААН, Байгууллагыг төлөөлж: Мөнгөн нуруу ХХК

26. Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:

27.Баталгаажуулсан: Т. Ганцэ

| БАТЛАВ | БАТЛАВ |
|---|---|
| ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ | “МӨНГӨН НУРУУ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ |
| С.ХАН-УУЛ | Л.ГАНСҮХ |
| 2025 оны ..... дугаар сарын ... ны/ний өдөр | 2025 оны .... дугаар сарын ... ны/ний өдөр |

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 25/....

Улаанбаатар хот

## Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Усны газрын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн Е-2505-000077 дугаар ус ашиглуулах дүгнэлт, Туул голын сав газрын захиргааны даргын 2025 оны 10 дугаар сарын ….. -ны/ний өдрийн А/..... дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Туул голын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн О.Дулмаа, Ус ашиглагчийг төлөөлж: 6470556 регистрийн дугаартай “Мөнгөн нуруу” ХХК-ийн Геологич С.Пүрэв-Очир нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

## Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт:

2.1.1. Хүдэр боловсруулахад ашиглах гадаргын ус;

2.1.2. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын ус;

2.1.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны усалгаанд ашиглах гадаргын ус;

2.1.4. Биологийн нөхөн сэргээлт хийхэд ашиглах гадаргын ус;

2.1.5. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах газрын доорх ус.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: **52,841.70 м$^3$/жил.**

2.2.1. Хүдэр боловсруулахад ашиглах гадаргын ус: 45,240.0 м$^3$/жил;

2.2.2. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын ус: 5,520.0 м$^3$/жил;

2.2.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны усалгаанд ашиглах гадаргын ус: 405.0 м$^3$/жил;

2.2.4. Биологийн нөхөн сэргээлт хийхэд ашиглах гадаргын ус: 619.20 м$^3$/жил

2.2.5. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах газрын доорх ус: 1,057.50 м$^3$/жил;

2.3. Усны чанар, найрлага: Унд ахуйн болон үйлдвэрийн технологийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн хариу болон дүгнэлтийг тухай бүр Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

2.4. Усны эх үүсвэр:

2.4.1. Байршил: Технологийн болон бусад хэрэглээний усыг Туул голоос, унд ахуйд ашиглах усыг зөөврөөр авч ашиглана.

2.4.2. Барилга байгууламж: Технологийн зориулалтаар ашиглах усаа голоос татаж 6,800.0 м$^3$ багтаамжтай усан санд хуримтлуулна. Эргэлтийн усан сан 38,000.0 м$^3$ багтаамжтай.

2.5. Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага: “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартыг мөрдлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодис, шинжилгээний дүн:

Ахуйн болон үйлдвэрийн дотоод хэрэгцээнд ашигласан уснаас гарах хаягдал усны хэмжээ, чанар найрлага, бохирдуулагч бодисын хэмжээ зэрэгт улирал тутамд шинжилгээг Ус цаг уур орчны шинжилгээний төвөөр хийлгэн хариу болон дүгнэлтийг тухай бүр Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх.

- Жинлэгдэх бодис /кг/;
- Органик бодис /кг/;
- Эрдэс бодис /кг/;
- Хүнд металл /кг/;
- Аюултай бохирдуулах бодис /гр/.

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

2.7.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.7.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ын дагуу тохижуулж ашиглана.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.8.1. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах;

2.8.2. Туул голоос ус татах насосыг байрлуулахдаа голын эрэг, голдирлыг хөндөхгүйгээр байрлуулна;

2.8.3. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 500.0 ш мод тарина.

2.8.4. Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг 17,000 м$^2$ талбайд хийнэ.

2.9. Усны тоолуур:

2.9.1. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллана. Туул голоос ус татаж буй насосын гаралт дээр тоолуур суурилуулна. Тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.10. Ус ашигласны нэгж, төлбөрийн хэмжээ:

2.10.1. Хүдэр боловсруулахад ашиглах гадаргын усны нөөц ашигласны төлбөр:

45,240.00 м$^3$ x 596.48 төг/м$^3$(2’651 төг/м$^3$ x 0.25 x 0.9) = **26,984,529.00 төг**

2.10.2. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын усны нөөц ашигласны төлбөр:

5,520.0 м$^3$ x 79.53 төг/м$^3$(2'651.0 төг/м$^3$ x 0.1 x 0.3) = **439,005.60 төг**

2.10.3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны усалгаанд ашиглах гадаргын усны нөөц ашигласны төлбөр:

405.0 м$^3$ x 18.56 төг/м$^3$(2’651 төг/м$^3$ x 0.01 x 0.7) = **7,515.58 төг**

2.10.4. Биологийн нөхөн сэргээлт хийхэд ашиглах гадаргын усны нөөц ашигласны төлбөр:

619.20 м$^3$ x 18.56 төг/м$^3$(2’651 төг/м$^3$ x 0.01 x 0.7) = **11,490.49 төг**

2.10.5. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

1,057.50 м$^3$ x 99.12 төг/м$^3$(9'440 төг/м$^3$ x 0.15 x 0.07) = **104,819.40 төг**

**Нийт төсөвт төвлөрүүлэх төлбөр:**
**26,984,529.00 төг + 439,005.60 төг + 7,515.58 төг + 11,490.49 төг + 104,819.40 төг = 27,547,360.08 төг**
(Хорин долоон сая таван зуун дөчин долоон мянга гурван зуун жаран төгрөг найман мөнгө)

2.10.6. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 6.5-р заалтын дагуу үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2 дахь заалтад заасны дагуу харъяа Татварын хэлтэст төвлөрүүлэх шаардлагатай;

2.10.7. Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасны дагуу ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах үүрэгтэй;

2.10.8. "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-ын 1.3-д заасны дагуу унд, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын усны олборлолт, дамжуулалт, нөөцлөлт, борлуулалт, хаягдал усны тоо хэмжээг тогтоох ба ашиглалтын тайлан мэдээ гаргах ажилд эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан усны тоолуурын заалтыг үндэслэнэ;

2.10.9. Усны тоолуурын заалтын баталгаа алдагдсан, тоолуурыг шугам хоолойноос салгасан, тоолуургүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын Сайдын 2015 оны А-301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож ногдуулахыг анхаарах;

2.10.10. Гэрээнд заасанаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-д заасны дагуу төлбөр тооцно.

2.10.11. Усны нөөцөд учирсан хохирлыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/37, А/31 дүгээр "Аргачлал шинэчлэн батлан тухай" хамтарсан тушаалын дагуу төлбөр тооцно.

## Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.5, 18 дугаар зүйлийн 18.1.4, 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.4, 26 дугаар зүйлийн 26.1, 30 дугаар зүйлийн 30.1, 30.6, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтад заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь цэвэр болон хаягдал усны лабораторийн шинжилгээний зардлыг бүрэн хариуцна.

3.3. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.4. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

## Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Энэхүү гэрээний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлэх бөгөөд талууд 2026 оны 01 дүгээр сард багтаан гэрээний хэрэгжилтийг дүгнэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол;
4.5.3. Ус ашиглах гэрээний үүргээ ноцтойгоор зөрчсөн;
4.5.4. Ус ашиглах зөвшөөрөл цуцлагдсан.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

УС АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Газрын доорхи усны нөөц, хяналт, шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

............................................(Э.МЯГМАРСҮРЭН)

Гадаргын усны нөөц, судалгаа шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн

............................................(Н.БОЛОР-ЭРДЭНЭ)

Уул уурхай, эрчим хүчний асуудал хариуцсан мэргэжилтэн

........................................................(О.ДУЛМАА)

Хаяг: Улаанбаатар хот-16050, Баянгол дүүрэг, 2-р хороо, Чингүнжавын гудамж, Туул голын сав газрын захиргааны байр, 203 тоот.

Харилцах утас: (976) 7000-3716.

УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Мөнгөн нуруу" ХХК-ийн Геологич

(С.ПҮРЭВ-ОЧИР )

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 13-р хороо, 3-р хороолол, 2д байр, 17 тоот.

Харилцах утас: 8801-5024, 9910-9815.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

# УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 10 -р сарын 03 -ны өдөр

Дугаар E-2505-000077

Улаанбаатар хот Утас: 265528, 265578

## 1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

| | |
|---|---|
| Оноосон нэр: | Мөнгөн нуруу ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар: | |
| Регистрийн дугаар: | **6470556** |
| Захирал: | **Гансүх** |
| Холбоо барих дугаар: | **88015024** |
| Факс : | |
| И-мэйл хаяг : | |

## 2.Төслийн нэр байршил

| | |
|---|---|
| Төслийн нэр: | **Дэнж** |
| Байршил: | **Сэлэнгэ, Орхонтуул, 3-р баг, Хонгор-Овоо** |
| Харьяалагдах сав газар: | **Туул голын сав газар** |
| Хамаарах салбар: | **Уул уурхай** |
| Төслийн дэлгэрэнгүй: | **Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших 290.05 га талбай бүхий MV-022165 тоот тусгай зөвшөөрөлтэй Дэнжийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл. 2025 онд 323.8 мян.м3 хөрс хуулж, 37.7 мян.м3 хүдэр боловсруулж, 12.2 кг алт авахаар төлөвлөж, хянуулсан байна.** |

## 3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

**Мөнгөн нуруу**

## 4. Ажиллах горим, хүчин чадал

| Үргэлжлэх хугацаа | Ажиллах горим | Жилд ажиллах хоног | Хоногт ажиллах ажилчидын тоо | Хоногт ажиллах цаг |
|---|---|---|---|---|
| 1 | 1 ээлжээр | 166 | 15 | 12 |

## 5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
|---|---|---|---|
| Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ | 37700.0 | тонн | Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын дэнж ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, маягт 3-д 37.7 мян.м3 хүдэр боловсруулахаар төлөвлөж, хянуулсан байна |

| Ажлын нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж | Тайлбар |
| --- | --- | --- | --- |
| | | | (технологийн усны 30%-ийг нөхөн сэлбэлтээр авч ашиглана) |
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 18400.0 | м2 | Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд 18,400.0 м2 талбайн тоос дарахаар тусгасан байна. |
| "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны арчилгаа усалгаанд ашиглах усны хэмжээ | 500.0 | ш | Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын дэнж ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, маягт 10-т 500 ш мод тарихаар төлөвлөж, хянуулсан байна. |
| Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 17200.0 | м2 | Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын дэнж ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, маягт 10-т 1.72 га талбайд биологийн нөхөн хийхээр төлөвлөж, хянуулсан байна. |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 47.0 | хоногт 1 хүн | Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын дэнж ордын 2025 оны уулын ажлын төлөвлөгөө, маягт 12-т үндсэн компанийн 47 хүн, 1 ээлжээр, 150 хоног ажиллахаар төлөвлөж, хянуулсан байна. |

## 6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

| Эх үүсвэр | Зориулалт | Усны нөөц (л) | Усны нөөц (м3) | Тайлбар |
| --- | --- | --- | --- | --- |
| Гадаргын ус | Технологийн хэрэгцээнд | 0.0 | 0.0 | Усны газрын 2023.09.04-ний өдрийн 146 дугаар усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах унд ахуйн 7.05 м3/хон усыг савласан усаар, технологи, зам талбайн тоосжилт дарах, ногоон байгууламжийн усалгаанд шаардагдах нийт 321.68 м3/хон усыг Туул голоос (урсац 16.83 м3/сек, шаардагдах усны хэмжээ 0.003 м3/сек буюу урсцын 0.02%) хангахад хүрэлцээтэй гэсэн байна. |

## 7.Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

| | |
| --- | --- |
| Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : | **Озем инвайрментал ХХК** |
| Холбоо барих : | **90098785** |
| Нэмэлт мэдээлэл: | |

## 8. Усны барилга байгууламжууд

| Барилга байгууламж | Хүчин чадал (м3) | Хэмжээ хийц |
| --- | --- | --- |
| Усан сан | 44800.0 | Технологийн зориулалтаар ашиглах усаа голоос татаж 6,800.0 м3 багтаамжтай усан санд хуримтлуулж, эргэлтийн усан сан 38,000.0 м3 багтаамжтай. |

## 9. Дамжуулах байгууламж

| Хаанаас (эхлэх цэг) | Хаана хүртэл (төгсгөлийн цэг) | Шугамын голч, мм | Дамжуулах шугамын урт, м |
|---|---|---|---|
| Гол | Усан сан | 159 | 1700 |

## 10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй байхыг анхаарах;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно;
- Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглоно;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх г.м;
- Хаягдлын сангийн зургийг мэргэжлийн байгууллагаар 2025 онд багтаан хийлгэж, Усны газраар дүгнэлт гаргуулах;
- Хаягдлын сангийн зураг төсөл хийлгээгүй тохиолдолд 2026 оны ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй болохыг анхаарна уу.

## 11. Усны зарцуулалт

| Ажлын нэр | Тоо Хэмжээ | Хэмжих нэгж | Усны хэрэглээ, м3 (Норм) | Гүйцэтгэх давтамж | Хэмжих нэгж | Нийт ашиглах усны хэмжээ, м3 | Хөнгөлөх усны хэмжээ м3 | Төлбөр тооцох усны хэмжээ м3 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ | 37700 | тонн | 4.0 | 1.0 | Удаа | 150,800.00 | 105,560.00 | 45,240.00 |
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 18400 | м2 | 0.002 | 150.0 | Хоног | 5,520.00 | 0.00 | 5,520.00 |
| "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны арчилгаа усалгаанд ашиглах усны хэмжээ | 500 | ш | 0.045 | 18.0 | Удаа | 405.00 | 0.00 | 405.00 |
| Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 17200 | м2 | 0.004 | 9.0 | Удаа | 619.20 | 0.00 | 619.20 |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 47 | хоногт 1 хүн | 0.15 | 150.0 | Хоног | 1,057.50 | 0.00 | 1,057.50 |
| **Нийт** | | | | | | **158,401.70** | **105,560.00** | **52,841.70** |

## 12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

| Ажлын нэр | Төлбөр тооцох усны хэмжээ, м3 | Усны ангилал | Хөнгөлөх хувь хэмжээ, % | 1 м3 усны үнэ | Усны нөөц ашигласны төлбөр, ₮ | Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮ | Төлбөл зохих дүн, ₮ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ | 45240.00 | Гадаргын ус | 0.0 | 596.48 | 26,984,529.00 | 0.0 | 26,984,529.00 |
| Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ | 5520.00 | Гадаргын ус | 0.0 | 79.53 | 439,005.60 | 0.0 | 439,005.60 |
| "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны арчилгаа усалгаанд ашиглах усны хэмжээ | 405.00 | Гадаргын ус | 0.0 | 18.56 | 7,515.58 | 0.0 | 7,515.58 |
| Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ | 619.20 | Гадаргын ус | 0.0 | 18.56 | 11,490.49 | 0.0 | 11,490.49 |
| Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ | 1057.50 | Газрын доорх ус | 0.0 | 99.12 | 104,819.40 | 0.0 | 104,819.40 |
| **Нийт** | **52,841.70** | | | | **27,547,360.08** | | **27,547,360.08** |

### 13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Ахуйн хэрэгцээнээс гарч буй бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэршүүлэн эргүүлэн ашиглах.
- Нөхөн сэлбэлтээр авч ашиглах усны хэмжээг 30%-иас хэтрүүлэхгүй байх;

### 14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;
- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах.

БАТЛАВ:

| | |
|---|---|
| СЭЛЭНГЭ АЙМАГ ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА: | МӨНГӨН НУРУУ ХХК-НИЙ ЗАХИРАЛ: |
| ............../М.ЦОГБАЯР/ | ............../Л.ГАНСҮХ/ |

# ХОГ ХАЯГДАЛЫН ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

Орхонтуул сум 2024 оны 02 сарын 20 өдөр

*ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО*

Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад гарсан ахиун хог хаягдлыг цаг хугацаанд нь шуурхай тээвэрлэж, цэвэрхэн эрүүл орчин бүрдүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

*ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ*

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь хэсгийн "д" дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 заалтууд, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 192, Б/243 тушаалуудыг тус тус үндэслэн нэг талаас Орхонтуул сумын Засаг дарга М.Цогбаяр нөгөө талаас Мөнгөн нуруу ХХК-ний захирал Л.Гансүх нар харилцан тохиролцож 2024 оны 02 дугаар сарын 15-наас 2025 оны 02 сарын 15-ны өдрийн хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

Мөнгөн нуруу ХХКомпани нь өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдалыг тогтоосон цаг хугацаанд тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага тавих эрхтэй.

1. Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 96 тоот тогтоолоор хог хаягдалын хураамжийн хэмжээг сарын 50.000 мянган төгрөг, жилийн 600.000 мянган төгрөгөөр тооцож хог хаягдлын төлбөрийг гэрээ байгуулсанаас эхлэн ажлын 5 хоногт багтаан 100131000947 Хог хаягдлын хураамж тоот дансанд хийх.
2. Монгол Улсын "Ариун цэврийн тухай" хуулийн 7.4, 17.1.4 дэх заалтыг үндэслэн гадаад орчноо бохирдуулахгүй хог хаягдлыг төвлөрсөн цэгээс өөр газар хаяхгүй байх үүрэгтэй. Компани нь Монгол Улсын Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, устгах үүрэгтэй.
3. Тусгай эмнэлэгийн байгууллагын хог, цацраг идэвхит болон химийн хортой бодис үйлдвэрлэл, туршилт, шинжилгээний ажил хийх үед компани нь сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

*ЭРХ, ҮҮРЭГ*

1. Монгол Улсын Хог хаягдын тухай хуулийн 12 дугаар заалтыг үндэслэн аж ахуй нэгж байгууллага иргэдээс хог хаягдал гаргасаны төлбөрийг нэхэмжлэн авах эрхтэй.
2. Тусгай хог хаягдлын Засгийн газрын 2006 оны 238 дугаар тогтоол, сумын ИТХ-ын баталсан журмын дагуу зөөж тээвэрлэж, зайлуулж байх үүрэгтэй.

3. Хог тээвэрлэлт, хог гаргасаны төлбөрийг заасан хугацаанд байгууллага, аж ахуй нэгж, иргэд барагдуулгүй тохиолдолд хоног тутмын 0,5 хувийн алданги тооцож ажиллана.

*БУСАД ЗҮЙЛ*

1. Өөрийн эзэмшлийн байшин барилга засварлах, буулгах тохиолдолд сумын Байгаль орчны албанд урьдчилан мэдэгдэж барилгын хог хаягдлаа тусад нь тээвэрлэнэ.
2. Гэрээгээр хоёр тал харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандах ба маргаантай асуудлыг зөвшилцөлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандаж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| СЭЛЭНГЭ АЙМАГ ОРХОНТУУЛ СУМЫН БОХУБАЙЦААГЧ: | МӨНГӨН НУРУУ ХХК: ЗАХИРАЛ: |
| ........................./О.МӨНХ-ЭРДЭНЭ/ | ........................./Л.ГАНСҮХ/ |
| ХАРИЛЦАХ УТАС: 91113517 | ХАРИЛЦАХ УТАС:88015024 |

**БАТЛАВ:**
**“ЭЛЕМЕНТ” ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**/Б.ЭНХБАДРАЛ/**

**БАТЛАВ:**
**“МӨНГӨН НУРУУ” ХХК-ИЙН**
**ЗАХИРАЛ**

**/Л.ГАНСҮХ/**

# ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№ ХБ-25/...179...

2025 оны 09-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хот

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас “**Элемент**” ХХК РД: /2100061/ /цаашид “**Гүйцэтгэгч**” гэх/ түүнийг төлөөлж, Ерөнхий менежер албан тушаалтай Б.Ундармаа, нөгөө талаас /цаашид “**Захиалагч**” гэх/-ыг **“Мөнгөн нуруу”ХХК** РД:/6470556/ түүнийг төлөөлж захирал Л.Гансүх нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг зориулалтын газарлуу ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.2. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

1.2.1 Устгал хийх хог хаягдлын мэдээлэл, үнэ /Хавсралт №1/
1.2.2 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг
1.2.3 Захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ
1.2.4 “Элемент” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

## ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эрхтэй:

2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,
2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй:

2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,
2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,
2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,
2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,
2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,
2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог хаягдал ачилт хийж өгөх.

2.2.9. Аюултай хог хаягдлаа гэрээний хүчинтэй хугацаанд багтаан 4.3-т заасны дагуу хүлээлгэн өгч устгуулах.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, "аюултай" гэсэн тэмдэглэгээтэй байхыг шаардах, хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд тулгуурлан тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдээлэл өгч зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

3.2.8. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг

## ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.

4.2. Энэхүү гэрээ 2025 оны 09-р сарын 23-ны өдрөөс 2026 оны 09-р сарын 22-ны өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэнэ.

4.3. Захиалагч гэрээний баталгаа болгож урьдчилгаа төлбөр болох **1,500,000.0 /Нэг сая таван зуун мянга/** төгрөгийг Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан дансанд байршуулснаар гэрээ батлагдана. Урьдчилгаа төлбөр нь гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн тээвэрлэлт, устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.

4.4. 4.3-т заасан урьдчилгаа төлбөр нь зөвхөн энэхүү гэрээний хүчинтэй хугацаанд үйлчилгээний төлбөрөөс хасагдаж тооцогдоно.

4.5. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжилнэ.

4.6. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн "Элемент" ХХК-ийн **1715164140 /Голомт банк/** тоот дансанд бэлэн бусаар төлнө.

4.7. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой обьектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ,

4.8. Төлбөр тооцоог зөвхөн Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан байгууллагын дансанд төлөх бөгөөд тус данснаас бусад хувь хүний дансандшилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

4.9. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэм буруутай тал нөгөө талдаа учирсан хохирлыг төлнө.

5.2 Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг Гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд ХАБЭА-н зааварчилгааны дагуу ажиллах үүрэгтэй.

5.3 Захиалагч талын байгууллагын бүсэд нэвтэрсэн тохиолдолд захиалагч талаас тавьсан ХАБЭА-н шаардлагыг гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд Элемент ХХК-ийн тээврийн хэрэгслийг давуу эрхийн дагуу хөдөлгөөнд оролцуулна.

5.4 Захиалагч тал гүйцэтгэгч талын ажлаа явуулах боломжоор байгууллагын хүрээнд хангаж өгөх үүрэг хүлээнэ.

5.5 Талууд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 12 дугаар болон бусад холбогдох зүйлд заасан шаардлагыг хангаан хамтран ажиллах үүрэгтэй.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.

6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй,эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.

7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

9.1. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

9.1.1. Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр,

9.1.2. Талууд харилцан тохиролцсож гэрээг цуцалснаар,

9.2. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна. Гэрээ дараах үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлагдана.Үүнд:

9.2.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа (2 ба түүнээс дээш удаа) биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй,

9.2.2. Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан,

9.2.3. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

## АРВАН. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА, БУСАД

10.1. Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

10.2. Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

10.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.

10.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.

10.5. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

10.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шударгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үүгээр баталж байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| Гүйцэтгэгчийг төлөөлж: | Захиалагчийг төлөөлж: |
| Ерөнхий менежер албан тушаалтай | Захирал албан тушаалтай |
| ................................./Б.Ундармаа/ | ................................... /Л.Гансүх/ |
| Утас: 89033790, 88103666 | Утас: 88015024 |
| Нягтлан бодогч албан тушаалтай | Е майл: Ganjaa86@gmail.com |
| ................................./Н. Пүрэвсүрэн/ | |
| Утас: 86103790 | |
| /Тамга, тэмдэг/ | /Тамга, тэмдэг/ |
| Харилцах утас: 8610-3790, 9910-7745 | Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 13р хороо, 2Д байр, 17 тоот |
| Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо, Бүс нуур /12610/ | |

*Химийн хортой болон аюултай бодисын хаягдал тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх ХБ-25/..179....... дугаартай гэрээний хавсралт №1*

Энэхүү гэрээгээр зөвхөн доорх хаягдлыг хүлээн авч хадгалан, устгал хийнэ.

| | АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нийт үнэ /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Ажилласан тос масло | кг | 1 | 1,100.0 |
| 2 | Тосны шүүр, арчих материал | кг | 1 | 4,500.0 |
| 3 | Аккумлятор | кг | 1 | 10,600.0 |
| 4 | Төмөр сав | кг | 1 | 4,500.0 |
| 5 | Дугуй | кг | 1 | 100.0 |
| 6 | Тээвэрлэлт /1тн хүртэл/ | рейс | 1 | 2,500,000.0 |

/Дээрхи тээвэрлэлт, устгалын зардал нь НӨАТ ороогүй дүн бөгөөд зардлыг тооцохдоо НӨАТ -ын 10% нэмж нэхэмжилнэ/

**Устгах арга аргачлал:** Дээрхи хог хаягдлыг зориулалтын эргэлтэт системтэй 2ST загварын шатаах зууханд 2 давхар шатаах камер (1-р камер 800⁰С, 2-р камер 1200⁰С)-т 99% шатааж устгалд оруулна. Шатаалтаас үүссэн үнсний хаягдлыг зориулалтын ландфиллын талбайд булшилж устгана.

**ХАВСРАЛТЫГ БАТАЛГААЖУУЛСАН:**

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Ерөнхий менежер албан тушаалтай

................................................/Б.Ундармаа/

Утас:89033790, 88103666

Захиалагчийг төлөөлж:

Захирал

................................/Л.Гансүх/

88015024

УЛААНБААТАР ХОТ МӨНГӨН НУРУУ ХХК 6470556 ГТА010716 9019090171

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

**Дагалдах бичгийн дугаар:**

**1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл**

Бүртгэлийн дугаар: Y | | | | |

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**

**Овог нэр (дармал үсгээр бичих)** Гарын үсэг (тамга) он сар өдөр

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**

**1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар:**

**Тээвэрлэгч аж ахуй нэгжийн нэр: "Элемент" ХХК**

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| № | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал | Савалгааны | Савны дугаар | Савны төрөл | Хэмжээ | Нэгж (кг, л) | Аюултай хог хаягдлын код | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | |
| 3 | | | | | | | | | | | | | | |
| 4 | | | | | | | | | | | | | | |
| 5 | | | | | | | | | | | | | | |
| 6 | | | | | | | | | | | | | | |
| 7 | | | | | | | | | | | | | | |
| 8 | | | | | | | | | | | | | | |
| 9 | | | | | | | | | | | | | | |
| 10 | | | | | | | | | | | | | | |

**5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

**6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:**

**1/ Овог нэр (дармал үсгээр бичих)** Гарын үсэг (тамга) он сар өдөр

**7. Үл зохицол:**

**8. Аюултай хог хаягдал хүлээн авагчийн мэдээлэл:**

Аж ахуй нэгжийн нэр: **Элемент ХХК** Бүртгэлийн дугаар: **0 0 0 0 1 1**

Аюултай хог хаягдал хүлээн авсан:

**Овог нэр (дармал үсгээр бичих)** Гарын үсэг (тамга) он сар өдөр

## АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000032 Огноо: 2023.09.25

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал Аюултай хог хаягдлийг цуглуулах, тээвэрлэх, устгах *(зөвшөөрлийн төрөл)* үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 9011082081 улсын бүртгэлийн дугаартай 2100061 регистрийн дугаартай Элемент ХХК -д 2023 оны 09 дугаар сарын 25 -ны өдрөөс 2028 оны 09 дугаар сарын 25 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000025

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар хот аймаг, хот Налайх сум, дүүргийн 3-р дугаар баг, хорооны бүс нуур /12610/, 77 тоот *(гудамж, байшин/хашааны дугаар)*

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар аймаг, хот Налайх сум, дүүргийн 3-р дугаар баг, хорооны бүс нуур /12610/, 77 тоот *(газрын нэр/гудамжны нэр, дугаар)*

**Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.**

**Зөвшөөрөл олгосон:**

| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | [signature, stamp] | Б.БАТ-ЭРДЭНЭ |
|---|---|---|
| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |

2023 оны 09 сарын 25 өдрийн

0000023 зөвшөөрлийн

1 хавсралт

| № | Тушаалын дугаар | Хугацаа | Олгосон өдөр |
|---|---|---|---|
| 1 | А/464 | 2023.09.25-2028.09.25 | 2023.09.25 |
| 2 | | | |
| 3 | | | |
| 4 | | | |
| 5 | | | |

| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | | Б.БАТ-ЭРДЭНЭ |
|---|---|---|
| (байгууллагын нэр, албан тушаал) | (гарын үсэг, тамга) | (овог нэр) |

**САНАМЖ:**

Тус яамнаас олгосон энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болгох үндэслэл болно.

**ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:**

ОБЕГ-аас олгосон Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрлийн эрхийн 0001 дугаартай гэрчилгээ бүхий

**ЭС ЭС АЙ ЭМ ЭН. ХХК**

**ЗАХИРАЛ** **Б.БАЯРЖАРГАЛ**

(Тамга: УЛААНБААТАР ХОТ, ЭС ЭС АЙ ЭМ ЭН ХХК, ТТТ1242 ☎5850576)

**Гамшгийн эрсдэлийн үнэлгээний багийн гишүүд**

Ерөнхий арга зүй, газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг

Гамшгийн эрсдэлийн үнэлгээчин Б.Баяржаргал

Техник технологийн холбогдолтой ослын эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зөрчигдсөнөөс үүсэх сөрөг нөлөөлөл, ил уурхайн гамшгийн эрсдэлийн нэгдсэн үнэлгээг

Гамшгийн эрсдэлийн үнэлгээчин Б.Одбаяр

Агаар мандлын гаралтай үерийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ,

Гео мэдээллийн зураглал болон тайланг эмхэтгэн боловсруулсан

Гамшгийн эрсдэлийн үнэлгээчин Н.Ганпүрэв

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

# ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар 0014257

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: "Мөнгөн нуруу" ХХК

Хаяг: Сэлэнгэ аймаг, Орхон туул сум.

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

Уул уурхайн

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.
/Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/
/Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4/

Олгосон: 2024 он 10 сар 16 өдөр
Хүчинтэй хугацаа: 2025 он 10 сар 16 өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:
Сэлэнгэ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга Хурандаа цолтой Г.Галбадрах

Дүгнэлт гаргасан:
Сэлэнгэ аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч Хошууч цолтой Д.Баясгалан

/тэмдэг дарна/






Зураг-1. Кемпийн гэрэлтүүлэг


DOOSAN
520LC


УУРХАЙН
БҮС








УУРХАЙН
БҮС





JUNCTION
81 27 УБЧ


Galaxy S22 Ultra


Galaxy S22 Ultra


Galaxy S22 Ultra



Зураг-1.. Засварын талбайг хатуу хучилттай болгосон байдал




Зураг-2. Галын сарай, галын хор, галын булан  000




Зураг-3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааны самбар, тэмдэг тэмдэглэгээ